

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХЫН ЭСРЭГ ТУСГАЙЛСАН ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ ЭСЭХ ТАЛААРХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГАА¹

УДИРТГАЛ

Хуулиа дээдлэн, хүний эрх, эрх чөлөөг хангах нь ардчилсан нийгмийн оршин тогтнох үндэс суурь юм. Хүний эрхийн гол зарчим бол хүний бие, сэтгэл, соёлын болон нийгмийн ялгаанаас үл хамааран бүх хүнд адил тэгш нөхцөл, боломж бий болгоход орших төдийгүй бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг Монгол Улс Үндсэн хуулиар тунхагласан.

Монгол Улсын Үндсэн хуулийн /цаашид “Үндсэн хууль” гэх/² Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж заасан. Мөн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” хэмээх Хоёрдугаар бүлэгт тус үндсэн эрхүүдийг хуульчлан баталгаажуулсан байдаг. Ингэхдээ хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр хариуцахаар үүрэг хүлээсэн.

Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн түвшинд хүний эрх, эрх чөлөөг хангах тухай авч үзэх бөгөөд Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 6 дахь удаагийн ээлжит тайланд Хүний эрхийн хорооноос гаргасан дүгнэлттэй холбоотойгоор өгсөн зөвлөмжүүдийг 2018-2021 онд ХЗДХЯ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Уг төлөвлөгөөний 8-д “Шууд болон шууд бус байдлаар ялгаварлан гадуурхах зэрэг төрийн болон хувийн салбарт ялгаварлан гадуурхахын эсрэг чиглэсэн дэлгэрэнгүй зохицуулалт бүхий хууль тогтоомжийг батлах” тухай заасан.

Иймд, дээрх хэрэгцээ шаардлагад үндэслэн Ялгаварлан гадуурхахын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэхийг тодруулахыг зорилоо.

Судалгааны аргачлал:

Тус судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу дараах үе шатаар хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Тухайн зохицуулалтын талаарх Олон Улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;

¹ Энэхүү үнэлгээг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, Ц.Оюунчимэг, У.Эрдэнэзаяа нар хамтран гүйцэтгэв.

² Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1

6. Дүгнэлт, зөвлөмж боловсруулах.

Дээрх дарааллын дагуу нэгдүгээрт “ялгаварлан гадуурхах”-тай холбогдох ойлголт, харилцааг судалж, ялгаварлан гадуурхалтад үүсэж буй асуудлыг тодорхойлохыг зорьсон болно. Үүний тулд Монгол Улсын болон бусад орны хууль тогтоомж, Олон Улсын байгууллагаас гаргасан баримт бичиг, Олон Улсын гэрээ, холбогдох ном сурах бичиг, өмнө хийгдсэн социологийн судалгаа, судалгааны тайлан, илтгэл, өгүүллийг уншиж судлах, харьцуулалт хийх болон бусад статистик мэдээллийг ашигласан бөгөөд асуудлын мөн чанар, түүний цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг болон тухайн асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тус тус тодорхойлов.

Асуудлыг тодорхойлсны дараагаар асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгоо томъёолж, тухайн зорилгод хүрэх хувилбарыг тогтоосон. Тухайн үе шатанд асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан дүгнэж хамгийн оновчтой хувилбарыг сонгон авч үр нөлөөг судлав.

Эцэст нь сонгон авсан хувилбарт үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх зорилгоор үнэлгээний ажлын эхэнд үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно.

Үндсэн хуулиар ялгаварлан гадуурхаж болохгүй шалтгаануудыг нэр заан тоочиж хуульчилсан байдаг. Эдгээр шалтгааныг үндэслэн хүмүүсийн эрхийн байдалд нэмүү боломж олгох буюу хязгаарлалт тогтоож болохгүй.³ Үүгээр энэ заалт нь хүний эрхийг хангах, эрх тэгш нөхцөлийг иж бүрнээр хуульчилсны хамт хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх тунхаглалаа хангах давхар баталгааг бүрдүүлсэн.

Эрх тэгш байх ойлголтын талаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэж заасан. Энэ заалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин сууж байгаа бүх хүнд адилхан олдсон, ашиглаж, эдлэх ёстой боломж юм. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэдэг нь хууль тогтоох, шүүх засаглалын эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аль ч хүний хувьд эрх, үүрэг, хариуцлага гэдэг гурван ойлголтыг ямар нэг ялгаваргүй тогтоох хэрэглэх үндсэн зарчим болдог. Эдгээр ойлголтын талаар товч дурдвал,

“Хүний эрх”-Хүн төрөлхөөсөө насан эцэслэтэл бусдад хохирол учруулахгүйгээр эдлэх өөрт нь заяасан эрх, эрх чөлөөтэй бөгөөд төрийн аливаа нэгдэл холбоо нь түүнийг хавчин хязгаарлаж болохгүй. Итгэл үнэмшилтэй, өмч хөрөнгөтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь тэдний төрөлхийн эрх чөлөө мөн.⁴

“Үүрэг”-Шударга хүнлэг ёсыг эрхэмлэн Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хуулиар ногдуулсан албан татвар төлөх, эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үндсэн үүрэгтэй байх бол хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр

³ Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх /харьцуулсан эрх зүй/ УБ., 1999 он.

⁴ Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг /Францын 1789 оны “Хүний ба иргэний эрх чөлөөний тунхаглал”-аас/ 92 дахь тал

хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг байдаг.⁵

“Хариуцлага”-Хууль зөрчсөн тохиолдолд бүгд адилхан шүүхийн шийдвэрээр хуулийн хариуцлага гарцаагүй хүлээх, шударга шүүхийн хууль ёсны шийдвэрийг бүгд адилхан биелүүлэх⁶ шаардлага бий юм.

Ийнхүү хүн бүр ялгаварлан гадуурхалтаас ангид эрх тэгш байх үндсэн зарчим хэрэгжих шалтгаан нөхцөл нь эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарладаг, нөгөө талаас хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын үйл ажиллагааны хүрээнд заавал удирдлага болох хууль зүйн эрх, үүрэг, хариуцлага гурав хүн бүрт адил тэгш үйлчилж байх явдал юм. Өөрөөр хэлбэл, төрөөс хүний эрхийг хангах, хамгаалахад тохирох үүрэг, хариуцлагыг ногдуулдаг аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах нь эрх тэгш байх үндсэн зарчим бүрэн утгаараа хэрэгжих баталгаа бүрдэх учиртай.

Харин хүн бүр нийгмийн харилцаанд оролцохдоо адил тэгш байх боломж байдаггүй. Ажил мэргэжил, боловсрол, насны зөрүүтэй байдал /хүүхэд, залуу хүн, хөгшин хүн/, өмчийн хувьд, авьяас чадвар, үзэл бодол, их бага орлого, ам бүл олон, цөөн байх зэргээс шалтгаалан өөр өөр байдаг. Тухайлбал, насаараа хөдөлмөр эрхэлсэн тэтгэвэр тогтоолгож буй хүнтэй ажил хөдөлмөрийн гараагаа эхлэж буй залуу болон сургуульд орж буй хүүхдэд үндсэн эрхээ эдлэхэд чиглэсэн төрийн үйлчилгээг адил тэгш үзүүлэхийн тулд тусгайлсан зохицуулалтаар зохицуулж хуульчилах, тогтоол, шийдвэр, захирамж гарган тэдгээр хүний үндсэн эрх хангагддаг байна.

Халдашгүй байх, амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, амрах, сурч боловсрох, үзэл бодлоо илэрхийлэх, бүтээл туурвих сонгох, сонгогдох, шашин шүтэх, эс шүтэх, эд хөрөнгө өмчлөх зэрэг үндсэн эрхүүдээр хүн эхийн хэвлийд бүрэлдэн бий болсон цагаас эхлэн үхэх хүртэл хангагдах талаар олон улсын гэрээ конвенц, Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор заасан байдаг. Эдгээр эрхийг эдлэхдээ хүн бүр бусдын эрхэнд халдахгүй байх зарчмыг баримтална.

Даяарчлагдаж буй өнөөгийн нийгэмд хүний эрхийг хамгаалан тунхаглаж буй төр нь халдашгүй дархан байх, улсын аюулгүй байдал, оршин тогтнох баталгааг бий болгосноор бусад улс орноос ирэх аюул, заналаас өөрийн иргэний үндсэн эрхийг хангах, хамгаалах үүргийг давхар хүлээж байдаг тул иргэн бүр төрөө дээдлэн хүндэтгэх, ёс суртахуун, төлөвшлийг бий болгон ард түмэн, газар нутаг, соёл түүхийн онцлог шинжээ хадгалан хамгаалах нь чухал юм.

Иймд НҮБ болон олон улсын жишгээс хоцрохгүйгээр өөрийн улсын онцлог шинжийг хадгалан хөгжих, хүний эрхийг дээдлэн хүндэтгэх явдал нь тулгамдсан асуудал болоод байна. Ф.Мартенс “Бүх боловсронгуй улс орон хүнийх нь хувьд үндэстэн харьяаллаас үл хамааран, бие хүнтэй салшгүй холбоотой мэдээжийн үндсэн эрхийг яс үндэс, харьяаллаас үл хамааран хүлээн зөвшөөрдөг”⁷ тухай дурдсанаас үзвэл хүний үндсэн эрхийг хүлээн зөвшөөрсөн байх нь тухайн улсын хөгжил дэвшилтэй (боловсронгуй улс) салшгүй холбоотой байна.

⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1, 1992 он, /Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйл/

⁶ Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх /харьцуулсан эрх зүй/ Уб., 1999 он. 25 дахь тал

⁷ Ф.Мартенс. Современное международное право цивилизованных народов. Т.1.СПб, 1882, с.327 /Ж.Амарсанаа. Хүний эрх номноос дам ишлэв./

НҮБ-ын Ерөнхий Ассамблей болон хүний эрхийн хороо нь олон улсын эрх зүйн салбарын хувьд хүний үндсэн эрх, эрх чөлөөг ямар нэгэн ялгаварлалгүйгээр энх тайвны цагт ч, зэвсэгт мөргөлдөөний үед ч хангаж мөрдөх улс орны үүргийг тодорхойлсон буюу эдгээр эрхийг зөрчсөний хариуцлагыг тогтоосон зарчим, хэм хэмжээний нийлбэр юм⁸ гэжээ. Ийнхүү Монгол Улс НҮБ-ын гишүүн орон болохын хувьд хүний үндсэн эрх, эрх чөлөөг ямар нэгэн ялгаварлалгүйгээр энх тайвны цагт ч, зэвсэгт мөргөлдөөний үед ч хангаж мөрдөх, урьдчилан сэргийлэх үүрэгтэй байдаг.

Төрөөс хүний үндсэн эрх, эрх чөлөөг ямар нэгэн ялгаварлалгүйгээр хангаж, урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн орчныг судлан үзвэл шууд утгаар ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалттай хууль 34, УИХ-ын тогтоол 5, шударга ёс, тэгш байдлыг хангах талаар зохицуулсан 81 хууль (*хавсралт 2*) хүчин төгөлдөр үйлчилж байна. Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг аливаа ялгаваргүйгээр, тэгш хангах зорилгоор зөвхөн тухайн харилцааг зохицуулахаар тусгагдсан, эсхүл нийтлэг харилцааг зохицуулахаар тусгагджээ.

Ийнхүү судалгааны хүрээнд хууль хоорондын уялдаа холбоо, хүний эрхийг хангахад чиглэсэн хуулийн үндсэн зарчим, хүний эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлэн хуульчилсан байдлаас аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байж тэгш эрхийг хангахтай холбоотой асуудал хэрхэн шийдвэрлэгдэж, хэрэгжих ямар арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлэх, ач холбогдол, эерэг, сөрөг тал, хууль боловсруулах шаардлагатай эсэхийг судлан үзнэ.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Ялгаварлан гадуурхахын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор дээрх тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудал анхаарал татаж байна. Үүнд:

- Төрөөс хүний үндсэн эрхийг хангах, ялгаварлан гадуурхалтын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;
- Ялгаварлан гадуурхахын эсрэг арга хэмжээг хэн, хэрхэн авч хэрэгжүүлж буй байдал;
- Хууль тогтоомжид тусгагдсан ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилт;
- Үндсэн хуулийн цэцээр (*Үндсэн хуулийн шүүхээр*) шийдвэрлэгдсэн байдал;
- Төрөөс хүний эрхийг хамгаалан, үүрэг, хариуцлагыг ногдуулдаг аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхад эрх тэгш байх механизмын үйлчлэл, хязгаар;
- Нийгэмд ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй айдас хүйдэс, үндсэн эрхээ эдлэх, тэгш эрхийн хэрэгжилтийг хангах нөхцөл боломж бүрдсэн эсэх.

Эдгээр асуудлыг харгалзан судалгааны цар хүрээг өргөн хүрээнд авч үзэх нь тохиромжтой байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлох

Өмнөх бүлэгт тодорхойлсон судалгаа гүйцэтгэх хүрээ, тулгамдсан асуудалтай холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна.

⁸ Ж.Амарсанаа. Хүний эрх /Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал/ УБ.,2000 он.

Хүснэгт 1. Эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа этгээд

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Нийгмийн бүлэг	Хүний үндсэн эрх зөрчигдөж, аливаа ялгаварлан гадуурхалтад өртөж буй байдлаас урьдчилан сэргийлж, хамгаалах нийгмийн бүлгийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх, хүчирхийлэлд өртөх явдлыг таслан зогсоох асуудал чухал байна.
2	Иргэд /18 наснаас дээш иргэний үнэмлэх авсан/	Иргэд үзэл бодол, нас, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, хүйс, албан тушаал зэргээр ялгаварлан гадуурхалтад өртсөнөөс үүдэн гарах үр дагаварыг багасгах шаардлагатай.
3	Аж ахуйн нэгж, байгууллага	Аж ахуйн нэгжүүд хөгжлийн түвшин, хөрөнгө чинээ, тухайн аж ахуйн нэгжийн удирдлага нийгэмд эзлэх байр сууриас шалтгаалан ялгаварлан гадуурхалтад өртөх зэргээр тэгш бус байдлын нөлөө нийгэмд тодорхой байр суурийг эзэлжээ.
5	Бусад этгээд	Үндсэн эрхээ эдлэх эрхтэй хүүхэд өөр хоорондоо нэгнийгээ нийгмийн орчин нөхцөлд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, нийтээр хүлээн зөвшөөрдөггүй нийгмийн цөөнхийг аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Монгол Улсын Үндсэн хуулиар хүний эрхийг дээдлэн, бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг тунхагласан тухай доктор, профессор Б.Чимид тайлбарлахдаа “Хүнийг дээдэлж, түүний эрх, эрх чөлөөт байдлыг хүлээн зөвшөөрч эрхэмлэсэн нь Үндсэн хуулийн язгуур үзэл баримтлалын нэг юм.”⁹ Хүний эрх, эрх чөлөөг зөвхөн Үндсэн хуульд тодорхойлсон томъёоллоор хязгаарлан ойлгож, судалж, үнэлж, хамгаалж болохгүй. Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн түвшинд авч үзвэл зохино”¹⁰ гэж үзсэн.

ХЭҮК-оос 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрүүдэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 623-н гомдол хүлээн авч шийдвэрлэсэнээс 6 нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхтэй холбоотой гомдол байна.¹¹ Дээрх тоон үзүүлэлтийг харвал Монгол Улсад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн зөрчил харьцангуй бага мэт харагдаж байгаа хэдий ч Мэдээллийн эрх чөлөөний төлөөх Хил хязгааргүй сурвалжлагчид олон улсын байгууллагаас гаргасан Хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол Улс 2016 онд 180 орноос 60 дугаар байр, 2017 онд 69 дүгээр байр, 2018 онд 71 дүгээр байранд тус тус орж сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол доошилсоор¹² байна.

Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг “Итгэл үнэмшилтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн арга нь үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө

⁹ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2017 он. 56 дахь тал.

¹⁰ Мөн тэнд. 194 дэх тал

¹¹ Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, 2018 оны үйл ажиллагааны тайлан, 18 дахь тал. <http://nhrcm.gov.mn/мэдээ/жил-хагас-жилийн-үйл-ажиллагааны-тайлан/>

¹² World Press Freedom Index, accessed April 1, 2019, <https://rsf.org/en/ranking/2018>

юм.”¹³, “Итгэл үнэмшилтэй байж Үзэл бодлоо илэрхийлэх нь хүний сэтгэл зүй, улс төр, ёс зүйн болон бусад шинжийг илэрхийлсэн процесс юм.”¹⁴ хэмээн авч үзсэн байх юм. Мөн “Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө нь:

- Мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар (үг хэлэх);
- Бичгээр буюу хэвлэлээр (хэвлэн нийтлэх);
- Уран сайхны хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх эрх;
- Түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо илэрхийлэх эрх;
- Эрж хайх (мэдээлэл авах);
- Хүлээн авах (мэдээлэл хүлээн авах);
- Түгээх;
- Тайван жагсаал, цуглаан хийх;
- Эвлэлдэн нэгдэх;
- Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх;
- Ажил хаях;
- Өлсгөлөн зарлах зэрэг эрх¹⁵ эрх чөлөөний эх сурвалж, төдийгүй анхдагч суурь эрх юм.”

Аливаа мэдээлэл нь мэдээллийн харилцаанд оролцогч субъектийн тодорхой үйлдэл, үйл ажиллагаанд дамжиж олон нийтэд хүрч, нийгмийн оюун санааны эрэлт хэрэгцээг хангаж байдаг. Энэ үйл ажиллагаа нь гурван үе шаттай байна.¹⁶ Үүнд:

- Нэг дэх шат: Мэдээлэл хайх эрх /freedom to seek/
- Хоёр дахь шат: Мэдээлэл олж авах /freedom to receive/
- Гурав дахь шат: Мэдээлэл тараах, түгээх /freedom to impart information/” ,

Иймд төрөөс үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахын зэрэгцээ мэдээллийн харилцаанд оролцогч субъектийн тодорхой үйлдэл, үйл ажиллагаанд (хүүхдэд мэдлэг олгох процесс хамаардаг) анхааран нийгмийн хөгжил, улсын аюулгүй байдал, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах нь зүйтэй байна.

Нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхагдах байдал нь бусад улс орнуудыг бодвол бага тохиолддог ч гэлээ бидний анзаарамгүй нөхцөл байдалд байнга хийгдэж байдаг. Тухайлбал, аль нэг байгууллагад анкет бөглөхдөө нийгмийн гарал гэсэн мэдээллийг заасан хүснэгтэд тэмдэглэн үлдээдэг. Энэ нь эцэг эхээ малчин, сэхээтэн, ажилчин гэж бөглөхөөс эхлэх юм. Тухайн байгууллага нь хувь хүний нууцыг хадгалах үүрэгтэй ч захиргааны зүгээс тухайн хүнд хандах хандлага, нөлөөлөх байдалд ялгаварлан гадуурхах хэлбэр болж байхыг үгүйсгэхгүй юм.

Хүний харагдах гадаад байдлаар ялгаварлан гадуурхах, хөгжлийн бэрхшээлээр нь ажиллах чадварыг үнэлэх явдал нь өнөөгийн нийгмийн ажиллах хүчний шалгуур болж байгаа нь мөн л асуудал дагуулсаар байна. 1999 онд батлагдсан *Хөдөлмөрийн тухай хуульд* 2003 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж,

¹³ ХБНГУ-н Ханнс Зайделийн сан, Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2009 он, 98 дахь тал.

¹⁴ Ж.Амарсанаа, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас, эргэцүүлэл, 2000 он, №7, 103 дахь тал.

¹⁵ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он, 2 дахь тал.

¹⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он, 2 дахь тал.

байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах тухай заасан. Гэтэл аж ахуйн нэгж, байгууллага хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд төлбөр төлдөг байна. Үүнийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-д төвлөрүүлж¹⁷ хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний нийгмийн хамгааллын арга хэмжээнд зориулагдаж, тэдгээрийг давтан сургах, ажлын байраар хангах, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд зээл олгох зэрэг арга хэмжээнд зарцуулагдаж байдаг. (ЗГ-ын 2019 оны 111 дүгээр тогтоол, хавсралт 2-оос үзнэ үү.)

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчдод, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн тусламж, урамшуулал олгох ажлыг зохион байгуулах тухай хуульчлан зааж өгсөн хэдий ч тэдний ажлын байрны орчин нөхцөлийг хангах нь хүндрэлтэй хэвээр байна. / “гадна”-шат, замын хашлага, хараагүй хүний хөтөч зам, унаа тээвэр, “дотор”-лифт, бариул, 00 өрөө, болон бусад орчинг бүрдүүлэх/

Монгол Улсын үндэстний цөөнх иргэдийн хүний эрхийн асуудалд онцгойлон анхаарч, ялангуяа үндэстний цөөнх хүүхдийн эх хэлээрээ сурч боловсрох, харилцах, мэдээлэл авах эрх, хөдөлмөр эрхлэлтийн асуудал тулгамдсан асуудал хэвээр байгаа нь анхаарал татаж байна.

Хүний эрхийн үндэсний комисс нь НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний эвсэлтэй хамтран 2016 онд Баян-Өлгий аймаг дахь хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд судалгаа хийжээ.¹⁸

Хүснэгт 2. Баян-Өлгий аймгийн хүн амыг угсаатны байдал¹⁹

№	Аймаг, сум	Бүгд	Угсаатны бүлгээр					
			Буриад	Дөрвөд	Казах	Тува	Урианхай	Халх
1.	Алтай	4191	12	7	2792	1	1363	16
2.	Алтанцөгц	2846	15	25	2288	1	444	73
3.	Баяннуур	5100	44	1	5010			45
4.	Бугат	3711	23	199	3345	2	109	33
5.	Булган	5231	19	11	4330		773	98
6.	Буянт	2768	23	6	1402	10	1302	25

¹⁷ Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. <http://nli.gov.mn/?p=4411> Хууль зүйн үндэсний хүрээлэн, УБ., 2018 он. /сүүлд үзсэн 2019.06.11/

¹⁸ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл. УБ., 2017 он.

¹⁹ Мөн тэнд. /Хүний эрхийн үндэсний комисс НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний эвсэлийн судалгаа/

7.	Дэлүүн	7236	39		7170			27
8.	Ногооннуур	6313	13	58	6155		46	41
9.	Сагсай	5188	19	10	4998	2	111	48
10.	Толбо	4123	28	16	4067			12
11.	Улаанхус	8789	86	29	8629		12	33
12.	Цэнгэл	9329	71	6	7770	13	13	160
13.	Өлгий	34305	251	393	31955	1142	1142	502
14.	Цагааннуур	1595	9	235	1295	6	25	25
	ДҮН	100725	652	996	91206	1393	5340	1138

Баян-Өлгий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 51 дүгээр тогтоолоор “Хос хэлээр сургалт явуулдаг сургуулийн сургалтын талаар баримтлах аймгийн бодлого, чиглэл”-ийг баталсан байна. Тус тогтоолыг батлах үед аймгийн статистик мэдээгээр 32 цэцэрлэгт нийт 6117 хүүхэд хүмүүжиж байснаас бүх цэцэрлэг сургалтаа казах хэлээр явуулдаг, мөн судалгаанд хамрагдсан хүүхдийн 3 хүүхэд тутмын 1 нь сургуулийн өмнөх боловсрол эзэмшээгүй, Монголоор мэндлэх энгийн үг хэллэгийг ойлгохгүйгээс нэгдүгээр ангид орохдоо хичээлээ гүйцэхгүй хоцордог, нийт 43 ерөнхий боловсролын сургуульд 22626 хүүхэд суралцаж байгаагаас 19283 нь Казах-Монгол, 278 нь Тува-Монгол хос хэлээр суралцдаг, хэлний ялгаанаас болж сургууль дээрээ 10 хүүхэд тутмын 6 нь хүчирхийлэлд өртдөг, казах хүүхдүүдээс илүү казах багш нар ялгаварлан гадуурхах нь их, хэлний цөөнх сурагчдын хувьд анги дэвших тусам сургуулийн багш, ажилтан, үе тэнгийнхний зүгээс ялгаварлан гадуурхах, зодох, шийтгэх, дээрэлхэх, үзэгдэл улам нэмэгддэг тухай онцлон тэмдэглэсэн байна²⁰.

Хэлний цөөнхөөс гадна бэлгийн цөөнх нь нийгмийн харилцаанд ялгаварлан гадуурхагдах нь гадаад төрх байдал, бусад байдлаар бий болсоор байна. Тухайлбал, үг хэл, үйлдлээр доромжлон хүчирхийлэх, ажлаас нь халах, ажлаасаа гарахаас өөр аргагүй байдалд хүргэх, гэрээсээ хөөгдөх, боловсрол болон мэдээлэл олж авах эрхийг үгүйсгэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхгүй байх, эсхүл үйлчилгээ үзүүлэхдээ элдвээр доромжлох, амь насанд нь халдах, халдахаар завдах, заналхийлэх, сүрдүүлэх зэрэг үзэгдэл байнга гардаг гэжээ²¹. Эрүүл мэндийн шалтгаанаар бэлгийн чиг баримжаагаа тодорхойлох боломжгүй, мэс засал, хагалгааны аргаар аль нэг хүйс тогтоолгож, албажуулан бүртгүүлснээр тухайн иргэн нийгмийн харилцаанд өөрийн байр суурийг тодорхойлдог.

Энэ хүртэлх хугацаанд тухайн хүний хүйсийн илэрхийлэл янз бүрийн байдлаар тодорч болох бөгөөд энэ нь хүний хөгжил (*нялх балчир үеийн зан байдал, өсвөр насны хүүхдийн зан байдал, залуу насны, идэр насны хүний зан байдал гэх мэт*), бэлгийн хөгжил,

²⁰ Мөн тэнд. /48 дахь тал/

²¹ Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн талаарх судалгаа, үр дагаварт хийсэн үнэлгээ. /2018 онд ХЗДХЯ-ны захиалга/,

үйл явцтай салшгүй холбоотой үзэгдэл юм. Үүнийг өмнө нь сэтгэцийн эмгэг гэж үздэг байсныг өндөр хөгжилтэй орон эрүүл мэндийн хувьд өвчин гэдгээр хүлээн авч ялгаварлан гадуурхах байдлыг өөр өнцгөөс тайлбарлан авч үздэг болсныг харгалзан үзэх нь зүйтэй болов уу. /Хөгжлийн бэрхшээлийн нэг хэлбэр гэдэг утгаар/ Харин зориудаар нийгмийн залуу, өсвөр үе, төлөвшил, хөгжил нь гүйцээгүй учраа олоогүй байгаа хүүхэд, залуусыг уруу татах, хүчирхийлэх, дарамтлах бэлгийн чиг хандлагын аль нэгийг хүлээн зөвшөөрүүлэх байдалд хүргэх, эргэлзээ тээнэгэлзээ бий болгох зэргээр нөлөөлөхгүй байх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, насанд хүрэх хүртэлх хүүхдийн төлөвшил хандлагад аливаа буруу үлгэр дууриалал үзүүлэх, гэмт санаа зорилгоор элдэв мэдээлэл хүргэснээр зан байдалд нь нөлөөлөх зэргээр зориудаар үйлдэх халдлагаас сэргийлэх нь тулгамдсан асуудал юм.

Нийгмийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор нь, хуулийн этгээдийг хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс хамааран ялгаварлан гадуурхах хандлага их болсон. Энэ талаар ХБНГУ-ын Фридрих-Эбертийн-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар “Цахим орчин дахь үзэн ядах үг хэллэг”²²-ийг шүүсэн судалгаа гаргажээ. Үүнийг зургаар үзүүлэв.

Зураг 1. Цахим орчин дахь үзэн ядах үг хэллэг



²² Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг. /контент анализын судалгаа/ ХБНГУ-ын Фридрих-Эбертийн-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар. 2018 он. <http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/14785.pdf> /сүүлд үзсэн 2019.06.11/

Чадваргүй, тэрбумтан өмгөөлөгч, өмгөөлөгч гэгдэх, ам ажил нь алд дэлэм зөрөгч, хууль бус авирлагч, яллагч (6 үг, холбоо үг)	Боловсрол Нийт 11 (5 үг, холбоо үг)	Чадваргүй, найдваргүй, дампуу, залилан мэхлэгч, худалч
Гомо, лесби, завхарсан, Эрийг эмэгчлэн, Эр хүйстэй "эмэгтэйчүүд", эмэгтэй болохыг хүсэх болсон эрчүүд, эмэгтэйлэг /эрэгтэй хүнийг хэлэх тохиолдолд/ (7 үг, холбоо үг)	Бэлгийн, хүйсийн чиг баримжаа Нийт 13 (6 үг, холбоо үг)	Гомо, лесби, анхан, хормойн донтой, завхай, завхарсан
Архичин (1 үг, холбоо үг)	Эрүүл мэндийн нөхцөл байдал Нийт 9 (8 үг, холбоо үг)	Архичин, донтон, ДОХ-той, тахир дутуу, солиотой, ухаанд нь ухна ишиг шүгэлсэн, сэтгэл мэдрэлийн өвчтэй, шизотой
Казак банди, тэмбүү, Орк, том шившиг, нухчин дарагч, "Эрийн муу эмд", ичих ч үгүй, новш, Нэгэн алд дөрвөн ямх нуруутай (8 үг, холбоо үг)	Ерөнхий нэр хоч өгсөн, доромжилсон Нийт 28 (20 үг, холбоо үг)	Нохойн баас, Казак банди, тэмбүү, Орк, дур царайлагч, уран донгодогч, шавар хаагч, өшөө авагч, улайрагч, ичих ч үгүй, булай, новш, гөлөгчүүд, тэмбүүнд тархиа идүүлсэн, хүчин, алуур хялдуур үйлдэгч, "Ямар гээчийн хар сүнсний алуурчин бэ", "Нүүр царайг нь нийтээ цацаж жигшүүлэх хэрэгтэй", "Туравхан сая хүнийг амийг нь хорлуулаад дуусгах даалгавар авсан амилсан шулам", "манайхан ч энэ хүүхдээр туг тахиж вий дээ"
Сошиал мангас Осоржамаа (1 үг, холбоо үг)	Бодит хүнд өгсөн доромж хоч Нийт 2 (1 үг, холбоо үг)	"урвагч" Доржзодов
57	189	132

Ийнхүү гадаад төрх байдал, нийгэмд эзлэх байр суурь, ажил мэргэжил, амьдарч буй орчин нөхцөл бусад олон хэлбэрээр нийгмийн харилцаанд ил, далд хэлбэрээр ялгаварлан гадуурхах нь хүнийг өөртөө итгэлтэй амьдрах, ажиллаж хөдөлмөрлөх, сурч боловсрох, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах үйл явцыг хойш татаж байдаг. Монгол Улсад аж төрөх, өөрийн улсын хөгжилд хувь нэмрээ оруулж чадах хүний хөгжил, ухамсар ёс суртахуун, соёл төлөвшилд суурилсан хүний эрхийг хангах асуудал дутагдалтай байгааг дээрх судалгаа харуулжээ.

Монгол Улсад эрх зүйн зохицуулалт, тогтолцоо бүрэлдэн тогтсон (*хуулиас гадна 2003 оны УИХ-ын 41 дүгээр тогтоолоор хүний эрхийг хангах ажил хийгдэж, түүнийг ЗГ-ын тогтоолоор хэрэгжүүлж байна*) ч өнөөгийн нийгмийн харилцаан дахь тэгш эрх, ялгаварлан гадуурхагдсан тохиолдол бүрийг хангалттай зохицуулж чадахгүй байна. Хэдийгээр батлагдан гарч буй хууль, зарлиг, батламж, шийдвэр нь Үндсэн хуульд нийцээгүй бол Үндсэн хуулийн цэц хүчингүй болгож, улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, хүний эрх, аливаа төрлийн ялгаварлан гадуурхах явдлыг эсрэг шийдвэр гаргаж байдаг (*хавсралт 3*) боловч энэ нь хууль тогтоомжийн уялдаа холбоо хангагдах, нийгмийн харилцаа бүрэн зохицуулагдах нөхцөл бүрдэхгүй юм. УИХ болон ЗГ-ын тогтворгүй байдал, ажлын уялдаа, залгамж холбоо алдагдсантай холбоотой хүний эрхийг хангах гол ажлыг УИХ-аас зохион байгуулж буй нь хангалттай бус байна. УИХ, ЗГ-ын тогтоол, бусад журмаар зохицуулагдаж байсан харилцаа сүүлийн үед зөвхөн хуулиар зохицуулагдаж, хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар хүлээлгэх болсон нь зарим харилцаа зохицуулалтгүй орхигдох явдал үүссэн байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Монгол анх 1946 онд НҮБ-д элсэн орох хүсэлт тавьж, түүнээс хойш жил дараалан элсэх тухай хүсэлтэд Аюулгүйн Зөвлөлийн гишүүн байсан янз бүрийн орнуудын байр суурь нааш цаашаа олонтаа өөрчлөгдөж, гадаад бодлого, дипломат бодлогын туршлага хуримтлуулаагүй, гадаад бодлого нь бие даасан бус байдалтай, хүний эрхийг хангах шалгуур давахгүй, НҮБ-ын дүрмийг биелүүлэхгүй байх магадлалтай гэх зэрэг шалтгаанаар

15 жилийн хугацаанд олон удаа түдгэлзэж байжээ.²³ ЗХУ-ын дэмжлэгтэйгээр 1961 онд хүлээн зөвшөөрүүлж элссэн бөгөөд бичиг үсэг, соёл, уламжлал, тусгаар тогтнолоо олон улс оронд хүлээн зөвшөөрүүлж, эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал, нийгмийн асуудлууд болон хүний эрхийн талаар хамтран ажиллах болжээ.

Төр нь ялгаварлан гадуурхахгүй байх үүргийг олон улсын хэм хэмжээгээр, үндэсний хууль тогтоомжоор хүлээснийг Монгол Улс хэрхэн биелүүлж буйд дүн шинжилгээ хийвэл тусгайлсан хуульгүй байгаа нь анхаарал татаж байна²⁴ гэжээ. Нэгдсэн, уялдаа холбоог хангасан зохицуулалт хийгдсэнээр нийгмийн хөгжлөөс гадуур орхигдож, эрх ашиг нь хөндөгдөж буй бүлгийн эрхийг хангах, хэрэгжүүлэх арга хэмжээ, байгууллагын эрх, үүрэг, зохион байгуулалтыг нарийвчлан зохицуулах нь зүйтэй байна.

Өсвөр ирээдүй үе, бусад өндөр хөгжилтэй улсын алдартай компанид тодорхой байр суурийг эзлэн ажиллаж буй Монголын эд эс бүхнээ хайрлан, хүний эрхийг дээдлэн хүндэтгэх аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалтад өртүүлэхгүй байх, мөн амьдрах нөхцөл боломж, зөв мэдээлэл авах, хөгжих боломжийг бий болгон газар нутаг, уул ус, газрын баялаг иргэдэд хүртээмжтэй аз жаргалтай амьдарч болох бүхий л боломжийг бүрдүүлэн, өөрийн улсын үнэт зүйлийг хайрлан хамгаалж, улам бүр өнгөлөн зүлгэж нээлттэй болгон “иргэн баян бол улс баян”²⁵ зарчмыг баримтлан дэлхийн бусад хөгжилтэй оронтой эн зэрэгцэх, тэдний дунд эзлэх байр сууриа нэмэгдүүлэхэд анхаарах нь туйлаас чухал юм.

Үндсэн хуульд заасан хууль шүүхийн өмнө эрх тэгш байх аливаа төрлөөр ялгаварлан гадуурхахын эсрэг хүний үндсэн эрхийг хангах нь төрийн үүрэг байтал ялгаварлан гадуурхагдах явдал улам бүр өргөжин тэлж буй байдал, мөн зам тээврийн осол, хорт хавдар, халдварт өвчин, бусад гэнэтийн байдлаар нас барагсдын тоо нэмэгдэж, агаарын бохирдол, ус байгалийн нөөц хомстох, газар нутаг сүйрэн доройтох, идэх хоол, өмсөх хувцас бүрийг хүний эрүүл мэндэд тустай гэж үзэх аргагүй болсон явдал нь манай улсын хүний эрхийг хангах асуудал дутагдалтай байгааг харуулж байна.

Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилго: “Хүний эрх тэгш байдлыг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулан уялдуулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой зохицуулах”.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, судалгаагаар тодорхойлсон “Хүний эрх тэгш байдлыг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулан уялдуулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой зохицуулах” зорилгыг хангаж чадах эсэх,

²³ Монгол Улс нэгдсэн үндэсний байгууллагын гишүүн болсон нь. Түүний түүхэн ач холбогдол. [file:///C:/Users/Turbayar/Downloads/374-Article%20Text-1515-1-10-20150105%20\(1\).pdf](file:///C:/Users/Turbayar/Downloads/374-Article%20Text-1515-1-10-20150105%20(1).pdf)
<http://www.info.mn/news/5948.htm> /сүүлд үзсэн 2019.06.14/

²⁴ Жэйм Фитцжералд “EQVAZ RIGHTS TRUST” олон улсын байгууллагын дэд захирал. <https://www.youtube.com/watch?v=5HYI62ySPsk> /сүүлд үзсэн 2019.06.14/

²⁵ Богд хаант Монгол Улсын үед гаалийн түшмэл байсан С.Данзан <http://www.info.mn/news/5948.htm> /сүүлд үзсэн 2019.06.14/

зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 1. Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн	
1	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгоо биелүүлэхэд зохих хэмжээгээр нөлөөлөх боломжтой. Гэвч өнөөгийн тулгамдаж буй бэрхшээлийг үр дүнтэй шийдвэрлэх боломжгүй буюу асуудал цаашид хэвээр үргэлжилнэ.	Зардал ихээхэн хэмжээнд шаардагдах бөгөөд ухуулга сурталчилгааг байнга идэвхтэй явуулахыг шаардана. Асуудлыг үүсгэх гол шалтгааныг арилгаж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдээр одоо байгаа зохицуулалтыг тодорхой түвшинд дэмжих, сайжруулах боломжтой болно.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Нэгдсэн зохицуулалтаар хүний эрх тэгш байх эрхийг хангах, ялгаварлан гадуурхалтад өртүүлэхгүй байх бүрэн боломжгүй.	Дан ганц санхүүжилтээр сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Төрийн бус байгууллагын оролцоог дэмжих нь чухал ач холбогдолтой хэдий ч тодорхой зохицуулалт дутагдалтай байх тул өнөөдрийн хууль тогтоомжийн хүрээнд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага ажиглагдахгүй байна.	Иргэний нийгмийн байгууллагыг оролцуулахад зохих хэмжээний зардал гарах боловч үр ашгаа өгнө.	Зарим үр дүн гарах боловч зорилгодоо хүрч чадахгүй
6	Захиргааны шийдвэр гаргах	Эрх тэгш байх эрхийг хангах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхагдаж байгаа тохиолдол бүрийг хязгаарлах зайлшгүй шаардлага бий тул Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “гагцхүү хуулиар хязгаарлах” ёстой. Иймд тус суурь харилцааг хууль тогтоомжоор хуульчлан баталгаажуулах нь оновчтой.	Хэдийгээр зарим асуудлыг Засгийн газрын тогтоол зэрэг захиргааны шийдвэрээр зохицуулж буй боловч зохицуулалтын түвшин харилцан адилгүй, үр өгөөжгүй болох талтай. Захиргааны шийдвэр гаргах нь асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад тухайлсан тохиолдолд нөлөөлөх боломжтой ч сөрөг	Зарим үр дүн гарах боловч зорилгодоо хүрч чадахгүй

			үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой болгох хувилбар байна.	Зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг шийдвэрлэхэд хамгийн үр дүнтэй арга зам юм.	Зорилгодоо хүрэх боломжтой, үр дүнтэй

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенц хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн холбогдох харилцааг өргөжүүлэх, чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд “Эрх тэгш байх эрхийг хангах тухай хууль”-ийг төсөл хэлбэрээр боловсруулах, эсхүл одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид үүрэг болгосон хориглосон зохицуулалтын санкцийн хэрэгжилтийг хангах, бусад аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхаж буй хэлбэрт ногдох зохицуулалтын аргыг судалж хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Ингэхдээ “Хүний эрх тэгш байдлыг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой зохицуулах” зорилгын хүрээнд дараах боломжит зохицуулалтын 2 хувилбарыг дэвшүүллээ.

1/ Хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулах;

2/ Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхсан тохиолдолд хуулиар хүлээлгэх хариуцлагыг оновчтой ногдуулах.

Зорилгод хүрэх байдал

Хувилбар 1. Иргэдэд тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдүүлэх, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, эрх тэгш нөхцөл байдлыг хангах нэгдсэн тогтолцоо нь хуулийн хүрээнд үйлчлэх нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч иргэдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшлэх юм.

Хүний эрхийг хангах, хамгаалах, аливаа төрлийн ялгаварлан гадуурхалт гарах байдлыг таслан зогсооход чиглэсэн 2003 оны УИХ-ын 41 дүгээр тогтоолоор нарийвчлан зохицуулсан зохицуулалтыг улам бүр сайжруулан хууль бий болгон бүрдэл хэсгийн чадавх, хүний эрхийг сахин биелүүлэх шаардлагатай. Үүний тулд:

Улсын Их Хурал нь хүний эрхийг хангах бодлогыг тодорхойлж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Засгийн газраас хүний эрхийн хүрээнд явуулж байгаа үйл ажиллагааг хянан шалгах, шүүх эрх мэдлийн хүрээний бодлогыг хууль тогтоох замаар тодорхойлох, энэ бүхэнд иргэд, тэдний олон төрлийн байгууллагын санал, оролцоог өргөтгөх замаар хүний эрхийг хангахад чиглүүлэгч, шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэнэ.

Засгийн газар нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллагын хувьд хүний эрх, эрх чөлөөний талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээ, энэхүү хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулж хангах ажлыг Улсын Их Хурлын өмнө шууд хариуцан хууль, гэрээний биелэлт, үр дүнг Улсын Их Хуралд, улмаар олон улсын гэрээний биелэлтийг НҮБ-д тогтмол тайлагнана. Засгийн газар хүний эрхийн талаарх хууль тогтоомжийн болон олон улсын

гэрээний биелэлтийг хангахын тулд төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагаас явуулж буй үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг хийнэ.

Хүний эрхийн төрөлжсөн байгууллагууд:

- Шүүх эрх мэдлийн байгууллага нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлж, шударга, хүртээмжтэй, эрх тэгш, бүтээлч байдлыг хангах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны хүнд суртал, чирэгдлийг арилгах, засаг захиргааны үйл ажиллагаанд тавих бүх төрлийн шүүхийн хяналтыг хүчтэй болгох замаар шүүхийг хүний эрх хамгаалах, зөрчигдсөн эрхийг нь сэргээн хангахад чиглүүлэх;
- Хүний эрхийн Үндэсний Комиссын бие даасан байдлыг бэхжүүлж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэн өргөтгөж, үр нөлөөг дээшлүүлэх,
- Нутгийн өөрөө удирдах байгууллага /аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал/ нь тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн өөрсдийн төлөөллийн байгууллага, шууд оролцоотой болохын хувьд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дээр хүний эрхийг сахин хангах, хамгаалах талаар нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагуудын харилцан ажиллагааг хүн амынхаа өмнөөс уялдуулах;
- Төрийн бус байгууллагууд нь засаг төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдах, шийдвэр гаргахад оролцох иргэний оролцоог өргөтгөн идэвхжүүлдгээрээ хүний эрхийг хангах механизмын нэн чухал хэсэг болно. Хүний эрх, хүний хөгжил, хүрээлэн буй орчинтой холбоотой хөтөлбөрүүдийг боловсруулах, биелүүлэх, хянан зохицуулах, үнэлэн дүгнэхтэй холбогдсон судалгаа, яриа хэлэлцүүлэг хийх, шийдвэр гаргах ажиллагаанд засаг төрийн бүх шатны байгууллага нь төрийн бус байгууллагууд, орон нутгийн үүсгэл санаачлагын бүлэглэлүүдийн хоорондын үр бүтээлч түншлэлийг хөгжүүлэх;
- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг өргөтгөн бэхжүүлэх, тэдгээрийн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх таатай орчин бүрдүүлэх, Хүний эрх, мөн олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн хэм хэмжээ, зарчмуудыг хувийн хэвшил нэгэн адил сахин биелүүлэх ёстойг иш үндэс болгож, тэдгээрт хууль ёсны шаардлага тавих зэрэг үйл ажиллагааг нэг бүрчлэн нарийвчлан зохицуулах, бусад холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах нь зүйтэй юм.

Хувилбар 2. Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхсан тохиолдолд хуулиар хүлээлгэх хариуцлагыг оновчтой ногдуулах, хууль хоорондын уялдаа холбоог хангах, тухайлсан харилцааг зохицуулахаар эсхүл нийтлэг харилцааг зохицуулсан хуулиудын зохицуулалттай нийцүүлэн тодорхойлох шаардлагатай.

Эрх тэгш байдал, шударга ёсыг хангах талаар зохицуулсан 81 хууль (*хавсралт 2*) хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнээс дурдвал;

- Ахмад настны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т “Гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч нь ахмад настныг нийгмээс тусгаарлах, ялгаварлан гадуурхах, нийгмийн харилцаанд оролцоход нь саад учруулах, хязгаарлах, түүнийг хөгжих, асран сувилах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийхийг хориглоно.”;

- Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т “Иргэдийг шашин шүтлэгийн ялгаа болон шашин шүтэх, эс шүтэх байдлаар нь ялгаварлан гадуурхах, доромжлох, хагалан бутаргах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.”;

- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “сэтгэцийн эмгэгтэй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохыг цээрлэх”;

- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.12-т “төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх”;

- Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх”;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т “хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих” гэх зэргээр тухайн харилцааг тусгайлан зохицуулсан.

Харин Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана”;

- Онц байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т “Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээ зааг нь бий болсон онцгой нөхцөлийн шаардлага, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгт нийцэж байхаас гадна хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байвал зохино”;

- Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйлийн “Ялгаварлан гадуурхах” гэсэн 1 дэх хэсгийн “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж;

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлийн “Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” гэсэн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж тус тус заажээ.

Ийнхүү нийтлэг байдлаар тусгасан дээрх хуулиудад ялгаварлан гадуурхагдсан тохиолдол бүрт нарийвчлан оногдуулах заалт тусгагдаагүй байх ба ерөнхий утгаараа Үндсэн хуульд зааснаас зарим хэсэг нэмэгдсэн байна. Жишээ нь: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд бэлгийн, хүйсийн чиг баримжаа /“хүйс” гэдэгт эрэгтэй, эмэгтэй,

бэлгийн чиг баримжаа нь “байдал” гэсэн Үндсэн хуулийн заалтад хамаарах нь зүйтэй болов уу/, хөгжлийн бэрхшээлтэй байдал болон хуулийн этгээдийн хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх тухай дэлгэрүүлэн зохицуулжээ. Дээрх хуулиудад үүрэг болгосон “хориглоно” гэж заасан заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын санкцийг зарим хуулиар тодорхой заагаагүй орхигдуулснаас уг хуулийн заалт хэрэгжих боломж хязгаарлагдмал байна. Иймд хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулан, хууль хоорондын уялдаа холбоог хангах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой ногдуулах нь тулгамдсан асуудал болсон байна.

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Иргэдэд тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдүүлэх, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, эрх тэгш нөхцөл байдлыг хангах нэгдсэн *тогтолцоог бүрдүүлэх, хүлээлгэх хариуцлагыг оновчтой* ногдуулах хувилбаруудад зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг шийдвэрлэхэд хамгийн үр дүнтэй арга зам юм. Иймд цаашид Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн зардал тооцох аргачлалын дагуу зардлыг тооцон гаргах нь үр дүнтэй юм.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгон авсан зохицуулалтын хувилбарын үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн болно.

4.1. Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Дэвшүүлсэн зохицуулалтын хувилбаруудыг ерөнхийд нь авч үзвэл хүн бүр ямар нэгэн алагчлалгүйгээр өөрийн салшгүй эрх, эрх чөлөөгөө эдлэх тэр боломжийг нь бүрдүүлэх, хүний эрхийг хангах, хамгаалах, хариуцлага тооцох механизмыг сайжруулахад тодорхой үр дүн гарч болно гэж үзэж байна.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Зохицуулалтын хувилбарууд нь дотоод болон дэлхийн зах зээлийн өрсөлдөх чадварт нөлөөлөхгүй. Харин аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргаанаас хүний тэгш эрхийг хангах чиглэлээр сургалт, семинар, хүний нөөцийг бэлтгэхэд тодорхой зардал гарах боломжтой.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин хүний эрх тэгш байх эрхийг хангах, аливаа ялгаварлахаас ангид байх зарчимд нийцсэнээр эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн байдлаар сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн

эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна хэмээн Үндсэн хуулиараа хүний эрхийг баталгаажуулсан нь НҮБ-ын конвенцийн зарчимд нийцэж байна.

Энэхүү үндэслэл нь бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг боловсруулах суурь болж байна. Иймд аливаа хэлбэрээр үл ялгаварлан гадуурхах ба хүний эрхийг хангах, хамгаалах үүргийг төр хүлээдэг тул эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага тулгараад байна.

ТАВ.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Монгол Улс НҮБ-д гишүүнээр элсэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг бүрэн хүлээн зөвшөөрч, улмаар "Иргэний болон улс төрийн эрхийн тухай", "Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай" олон улсын пакт зэрэг хүний эрхийн талаарх НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудын олон улсын 30 гаруй гэрээнд нэгдэн орж, хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үйлсэд зохих амжилт олсоор ирсэн. НҮБ-ын гишүүн 190 гаруй орноос ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтыг судлан үзвэл */Хавсралт 4-өөс үзнэ үү.*²⁶ тусгайлсан хуультай 18 орон байна. Эдгээр улсуудаас Европын Холбоо, ИБУИНВУ, ХБНГУ, Австрали Улс, АНУ болон Колумба Улсын алагчилах үзлийг хууль тогтоомжид хэрхэн тусгалаа олсон талаар 8-9 нийтлэг шинжээр алагчилах үзэл гаргах явдлыг хориглосон байна. Эдгээр шинжүүдийг хуулийн зорилго болгон тусгасан байх боловч ихэнх тохиолдолд нийтлэг харилцаанд авч үзжээ.

Нэг. Европын Холбоо

Европын Холбооны гишүүн орон “Ялгаварлан гадуурхахын эсрэг хууль” тэр дундаа “Арьс өнгөөр тэгш байх зааварчилгаа”-нд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, гадаадын иргэдээс айх үзэл, үзэн ядах гэмт хэргийн эсрэг зэрэг асуудлыг авч үздэг байна. Энэхүү хууль зүйн баримт бичиг нь олон салбарт үйлчилдэг. Тухайлбал, ажил эрхлэлт, нийгмийн хамгаалал болон нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээ, мөн нийгмийн давуу эрх, боловсролын үйлчилгээ, шашин шүтэх, ажил олгох, мэргэжил эзэмшихэд нь ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг өргөн хүрээнд зохицуулагддаг.²⁷

Европын Холбоо нь олон нийтийг хамарсан, хүчирхийлэлд өдөөн турхирсан үйлдлийг гэмт хэрэгт тооцон шийтгэл ногдуулах талаар, эрүүгийн хууль тогтоомжид хуульчлахыг зөвлөмж болгосон. Энэхүү баримт бичиг нь гишүүн орнуудад үл ялгаварлах, тэгш хандах үүрэг хүлээсэн бөгөөд тус холбоо нь гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийг хамгаалалтад авах журам боловсруулсан байна.

²⁶ <http://hdr.undp.org/en/countries>

Монгол Улсын НҮБ-д илгээсэн тайлангууд: <http://hdr.undp.org/en/countries/profiles/MNG>
https://www.unicef.org/about/annualreport/files/Mongolia_2017_COAR.pdf

НҮБ тус конвенц-д нэгдсэн улс орнуудын илтгэл, тайлангууд:
https://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/TBSearch.aspx?Lang=en&TreatyID=6&DocTypeID=27 /сүүлд үзсэн 2019.06.17/

²⁷ Европын Холбооны мэдэгдэл, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн №73 чуулган 3 дугаар хороо, 2018 /уг мэдэгдэлд Турк, Бүгд Найрамдах Макадони, Монтенегро, Серби, Албани, Босни ба Херцеговина, Украин, Молдав, Жеоржиа улсууд мөн нэгдэж буйгаа илэрхийлсэн/, Сүүлд зочилсон 2019-03-22:
https://eeas.europa.eu/delegations/un-new-york/52953/eu-statement-%E2%80%93-united-nations-3rd-committee-elimination-racism-racial-discrimination_en

Европын Комисс нь яг тодорхой асуудлаар санаачлага /цахим сүлжээн дэх хууль бус үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх, менежментын асуудлыг дэлгэрүүлэх г.м/ гаргаж, эрх бүхий байгууллага, иргэний нийгэмд зориулсан төслийн санхүүжилтийн санг байгуулан Эрх тэгш байдал болон Иргэний хөтөлбөр боловсруулсан байна. Энэ хөтөлбөр нь шашны болон цөөнхийн бүлэглэлд байгаа хүмүүсийг хамгаалах асуудлыг зохицуулсан байх бөгөөд тэр дундаа Европын Комиссоос томилогдсон Антисемитизм буюу Жүүдүүдийн эсрэг үзэл, мөн Муслам шашинтай иргэдийг үзэн ядахтай тэмцэхэд чиглэгджээ. Европ дахь шинэ, хуучин Антисемитизм буюу Жүүдүүдийн эсрэг үзэл, тэдний нөхцөл байдлын талаар олж мэдэх зорилгоор 2018 оны 12 дугаар сард “Жүүдүүдийн эсрэг үзлийн тухай” судалгааг Европын Холбооны Хүний эрхийн агентлаг явуулсан байдаг.

Европын Комисс нь бүх хүмүүсийн тэгш эрхийг хангах, тэр дундаа Европын Холбоон дахь Африк гаралтай иргэдийг арьс өнгөөр ялгаварлан гадуурхах асуудалд тусгайлан анхаарал хандуулдаг байна. Ийнхүү “Afrophobia” гэх нэр томъёог тусгайлан судалж, хэлэлцүүлэг зохион байгуулж ихээхэн хүчин чармайлт гаргасны үр дүнд Европын Комиссоос гаргасан төслийн баримт бичигт тусгалаа олж, улмаар 2018 оны 5 дугаар сарын 14-17-ны хооронд Европын Парламентаас зохион байгуулсан “Европын Холбоо Африк гаралтай иргэдийн 7 хоног” гэсэн чуулганаар хэлэлцэгдэн, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх зорилготой дүгнэлтэд тусгалаа олсон байна.

Хоёр. ИБУИНВУ

ИБУИНВУ нь 2010 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Тэгш байдлын тухай хууль баталснаар өмнө үйлчилж байсан алагчилах үзлийн эсрэг хуулиудыг нэгтгэж зохицуулах болсон байна.²⁸

Энэ хуулийн “нэр томъёо” II тал, I бүлэг, 4 дүгээр зүйлийн “Хамгаалагдах шинжүүд” хэсэгт нас, хөгжлийн бэрхшээл, жендэр, гэрлэлт болон иргэний түншлэл, жирэмслэлт болон жирэмсний байдал, арьс, шашин эсхүл итгэл үнэмшил, хүйс болон бэлгийн чиг хандлага зэрэг 9 шинжийг тусгасан байдаг.

Мөн тус хуульд шууд²⁹, холимог алагчилах³⁰ болон шууд бус алагчилах³¹ үзэл гэж ангилсан байдаг.

Шууд алагчилах нь хамгаалагдсан шинжүүдээс шалтгаалан үл нааштай хандсан эсхүл бусдад хэрхэн хандах байсан тийм байдлаар адил хандаагүй, гэрлэсэн болон иргэний түнш гэдгээр алагчилан хандсан, эмэгтэй хүн хөхөөр хооллох аргыг сонгосон гэсэн шалтгаан байх зэрэг, *холимог алагчилах үзэл нь* хамгаалагдах шинжүүдээс хоёр болон түүнээс дээш шинжээр хамтад нь үл нааштай хандсан эсхүл тэдгээр шинж байхгүй бусад этгээдэд хэрхэн хандах байсан тийм хандлагаар хандаагүй зэрэг тохиолдлыг, *шууд бус алагчлах нь* холбогдох хамгаалагдах шинжээр нь шалгуур үзүүлэлт болгож, эсхүл холбогдуулан хандсан гэж үзсэн бол, холбогдох хамгаалагдах шинжээр нь шалгуур үзүүлэлт болгон, эсхүл холбогдуулан хандсан нь алагчилах үзэл гаргасан харилцаанд хэрэгжсэн гэж үзнэ.

²⁸ Сүүлд зочилсон: 2019-05-07: <https://www.gov.uk/guidance/equality-act-2010-guidance>

²⁹ ИБУИНВУ “Тэгш байдлын хууль” (2010), 13 дүгээр зүйл. <https://www.gov.uk/guidance/equality-act-2010-guidance> /сүүлд үзсэн 2019-05-07/

³⁰ Мөн тэнд. 14 дүгээр зүйл.

³¹ Мөн тэнд. 19 дүгээр зүйл.

Хуулийн 25 дугаар зүйлд³² “Алагчилах үзлийн тусгайлсан тохиолдлууд”-д зохицуулсан байдаг. Уг хуулийн “Үл алагчилах үзлийн дүрэм” 61 дүгээр зүйлд “(8) Хатан хааны Сайдын зарлигт тодорхойлсон үл алагчилах үзлийн дүрмийг баримтлан шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулсан эрх бүхий ажил олгогч, итгэмжлэгдсэн этгээд болон менежер уг дүрмийн хүрээнд явагдсан бол тэрхүү харилцааг үл алагчилах үзлийн дүрмийг зөрчөөгүй гэж үзнэ.” гэж хуульчилсан байдаг.

Гурав. ХБНГУ

ХБНГУ-д аливаа хэлбэрээр алагчилах үзлийг хориглосон бөгөөд Европын Холбооноос гаргасан Алагчилах үзлийн эсрэг 4 зааварчилгааг³³ өөртөө нэгтгэсэн. 2006 оны 8 дугаар сарын 14-ний өдөр “Тэгш хандах тухай ерөнхий хууль”³⁴-ийг батлан гаргасан.

Тус хуулийн зорилго³⁵ нь дараах нийтлэг долоон шинж болох арьс өнгө, гарал үүсэл, /угсаа язгуур/, хүйс, шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзэл, хөгжлийн бэрхшээл, нас болон бэлгийн чиг хандлагын улмаас хуулиар зохицуулсан харилцаанд ялгаварлан гадуурхах явдлаас хамгаалахад чиглэсэн байна. Эдгээр шинж бүрээр ялгаварлан гадуурхаж болохгүй тохиолдлуудыг заан тодорхойлсон. Үүнээс гадна хуулийн 20 дугаар зүйлд алагчилах үзэл гаргахыг зөвшөөрсөн нөхцөлийг хуульчилжээ. Үүнд:

1. аюул заналхийллээс зайлсхийх болон, гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэхэд, эсхүл харьцуулсан шинж бүхий бусад зорилгоор;

2. хувь хүний халдашгүй болон аюулгүй байдлыг хамгаалах шаардлагыг хангахаар бол;

3. тусгай тэтгэмж бүхий давуу байдал олгох болон тэгш хандахыг албадах ашиг сонирхол үгүй бол;

4. эрх ашиг нь хөндөгдсөн этгээдийн шашин болон шашин шүтэх эрх, эрх чөлөө эсхүл шашны нийгэмлэгийн өөртөө засан тохинох эрхээ эдлэх зорилгоор болон тэдгээрт зориулсан (хууль зүйн хэлбэрийг үл харгалзан) байгууламж болон хамтдаа шашин шүтэх, эсхүл тэдний хүндэтгэж буй үзэл санаа, итгэл үнэмшилтэй байхад нь зориулсан байгууллагад нэгдэх нь зөвтгөгдсөн үед шашин, хөгжлийн бэрхшээл, нас, бэлгийн чиг хандлага, эсхүл хүйсээр алагчилах нь зорилго бүхий үндэслэлтэй байвал алагчилсан гэж үзэхгүй..” гэж заасан байдаг.

Дөрөв. Австрали Улс

Австрали Улсад ялгаварлан гадуурхахын эсрэг хууль тогтоомж нь холбооны болон муж улсын түвшинд үйлчлэх бөгөөд олон нийтийн дунд ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэхээс хамгаалахад чиглэсэн байдаг. Холбооны хууль нь муж улсын нутаг дэвсгэрийн хуулиудтай нэгэн зэрэг үйлчлэх хүчин чадалтай байдаг.

Австрали Улсад ялгаварлан гадуурхахын эсрэг Австралийн Хүний Эрхийн Комиссын тухай хууль (1986), Шударга ажлын тухай хууль (2009)-ийг гол хууль болгон авч үздэг бөгөөд Насаар алагчилахгүй байх тухай хууль (2004), Хөгжлийн бэрхшээлээр алагчилахгүй

³² “References to particular strands of discrimination” гэдгийг “Алагчилах үзлийн тусгайлсан тохиолдлууд” гэж авч үзэв.

³³ Сүүлд зочилсон: 2019-06-14, https://www.antidiskriminierungsstelle.de/EN/TheAct/theAct_node.html

³⁴ Тэгш хандах тухай ерөнхий хууль (2006), Сүүлд зочилсон: 2019-06-14, <http://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/77201/93329/F695840346/DEU77201.pdf>

³⁵ Эрх зүйн үзэл баримтлал: шинэ хандлага, Олон улсын бага хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2012, 51 тал.

байх тухай хууль (1992), Арьс өнгөөр алагчилахгүй байх тухай хууль (1975), Хүйсээр алагчилахгүй байх тухай хууль (1984) гэсэн 6 хуулийг Холбооны хэмжээнд дагаж мөрддөг байна.

Харин Австрали улсын нийслэл дэх нутаг дэвсгэрт: Алагчилах үзлийн тухай Акт 1991, Шинэ өмнөд Уэльсийн нутаг дэвсгэрт: Алагчилахын эсрэг Акт (1977), Хойд нутаг дэвсгэрт: Алагчилахын эсрэг Акт (1992), Хатан хааны нутаг дэвсгэрт: Алагчилахын эсрэг Акт (1991), Өмнөд Австралид: Тэгш боломжийн Акт (1984), Тасманид: Ялгаварлахын эсрэг Акт (1998), Викториад: Тэгш боломжийн Акт (2010), Баруун Австралид: Тэгш боломжийн Акт (1984) зэрэг нь муж улсын нутаг дэвсгэрийн тухайд үйлчилдэг байна.

Эдгээр хууль тус бүрээр алагчилах үзлийн шинжүүдийг тусгасан байх бөгөөд нийтлэг “арьс, арьсны өнгө, улс төрийн үзэл баримтлал, үндэстний удам, нийгмийн гарал, нас, эрүүл мэндийн талаарх тэмдэглэл, эрүүгийн гэмт хэрэгтний талаарх тэмдэглэл, гэрлэлтийн болон харилцааны төлөв, аль нэг эрхтний хөгжил сааталтай байх, сэтгэлгээ, оюуны эсхүл сэтгэц мэдрэлийн хөгжлийн бэрхшээл, бие махбодын хөгжлийн бэрхшээл, үндэстэн байх, бэлгийн чиг хандлага болон үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа зэрэгт үндэслэн ялгавартай хандах” гэж заасан³⁶.

Австралийн муж, нутаг дэвсгэрийн түвшний хэмжээнд үйлчилж буй алагчилах үзлийн тухай хуулиудын хэрэгжилтийг муж, нутаг дэвсгэрийн тэгш боломж болон алагчилахгүй байхын эсрэг агентлагууд хариуцдаг байна.

Тав. Америкийн Нэгдсэн Улс

АНУ анх удаа 1866 оны Иргэний хуульд³⁷ тодорхой эрхүүдийг хамгаалах, тэдгээр эрхийг алагчилах үзэл гаргах явдлаас хамгаалах зорилгоор буюу Өмнөдийн эрх чөлөөг олсон хүмүүсийг хамгаалахаар уг хуулийг баталсан байдаг.

Алагчилах үзлийн тухайд АНУ-ын хувьд 1964 оны Иргэний хууль, Хөдөлмөр эрхлэлтэд алагчилах үзэл гаргахын эсрэг хууль (“ADEA”), 1990 оны Хөгжлийн бэрхшээлтэй Америк иргэдийн тухай хууль (“ADA”), 1963 оны Тэгш цалин олгох тухай хууль (“EPA”), 1978 оны Жирэмсэн байдлаар нь алагчилахын эсрэг хууль (“PDA”), 2008 оны Генийн мэдээллээр алагчилахын эсрэг хууль (“GINA”)³⁸ болон бусад мужийн батлагдсан хүчин төгөлдөр хуулиар аливаа алагчилах үзэл гаргах явдлаас хамгаалдаг байна.

1964 оны Иргэний хууль болон бусад Холбооны холбогдох хуулиар хүн ам дахь зарим бүлгийн хүмүүсийг “нас, арьс, үндэстний гарал, шашны итгэл үнэмшил, жендэр, хөгжлийн бэрхшээл, жирэмслэлт, ахмад дайчин байсан” зэрэг үндэслэлээр алагчилах үзэл гарган хандахыг хориглодог байна. Мөн мужийн хуулиар жендэрийн байдал, бэлгийн чиг хандлага, улс төрийн үзэл санаа, цэрэг армид алба хаасан байдал зэргээр алагчилах үзэл гаргахын эсрэг хуульчилсан зэрэг шинжүүдийг хууль тус бүрээр зохицуулсан байна. Тухайлбал, насны шинжээр нь хөдөлмөр эрхлэхэд алагчилах үзлийг хориглох заалтад Насаар

³⁶ Насаар алагчилахгүй байх тухай хууль (2004), Хөгжлийн бэрхшээлээр алагчилахгүй байх тухай хууль (1992), Арьс өнгөөр алагчилахгүй байх тухай хууль (1975), Хүйсээр алагчилахгүй байх тухай хууль (1984), Шударга ажлын тухай хууль (2009)-ийн хэрэгжилтийг холбооны хэмжээнд Австралийн Хүний Эрхийн Комисс хариуцдаг.

³⁷ Michael J. Perry, *The Constitution, the Courts and Human rights*, Wiley Eastern Limited, 1982, P.62

³⁸ (Title VII and Title II of the Civil Rights Act of 1964) (Age Discrimination in Employment Act) (Americans with Disabilities Act), (Equal Pay Act), (Pregnancy Discrimination Act), (Genetic Information Non-Discrimination Act) Сүүлд зочилсон: 2019-06-14, <https://knowledge.leglobal.org/anti-discrimination-laws-in-usa/>

алагчилах тухай 1975 оны хууль АНУ Код 42, 6101-6107 хэсгийг³⁹ буюу Холбооноос санхүүгийн туслалцаа авах хөтөлбөр, үйл ажиллагаанд насанд үндэслэн алагчилах үзэл гаргахыг хориглосон жишээг дурдаж болох юм.

Зургаа. Колумбын Бүгд Найрамдах Улс

КБНУ нь 1948 оны 5 дугаар сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон Хүний эрх үүргийн тухай Америкийн тунхаглалыг⁴⁰ баталсан буюу нэгдэн орсон орны нэг юм.

Тус тунхаглалын 2 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө эрх тэгш мөн хүнийг арьс, хүйс, хэл, итгэл үнэмшил болон бусад зүйлээр ялгаварлахгүй энэхүү тунхагт заасан эрхийг эдлэж үүрэг хүлээнэ.” гэж шинжүүдийг заасан байна. Мөн КБНУ-ын Конгрессоос 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталсан 1482 тоот хуулийн⁴¹ 1 дүгээр зүйлд “арьс, угсаатны гарал, шашин, үндэстэн, улс төрийн эсхүл философийн үзэл санаа, хүйс, бэлгийн чиг хандлага, хөгжлийн бэрхшээл болон бусад шалтгаанаар алагчилах үзэл гаргасан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд энэ хуулийн зорилт оршино.” хэмээн хуульчилжээ.

КБНУ-ын Эрүүгийн кодын II ном, I бүлэг, 2о дугаар зүйлийн “Алагчилах үйлдэл” хэмээх IX дэд бүлэгт 134 А зүйлд “... аливаа хүнийг арьс, үндэстэн, хүйс, бэлгийн чиг хандлагаар алагчилсан эсхүл арьс өнгөний үзэл гаргасан бол буруутай этгээдийг 12, 36 сарын хугацаагаар хорих, 10-15 хүртэлх сарын цалингийн доод хэмжээгээр албадан торгоно” гэсэн заалт, мөн Эрүүгийн кодын 134В дүгээр зүйлд “...алагчилах үзлийг: 1. Олон нийтийн газар, олон нийтэд зориулсан мөн олон нийтэд нээлттэй газарт, 2. Олон нийтийн хэвлэлд, 3. Төрийн албан хаагч үйлдсэн, 4. Уг үйлдэл нь хүүхэд, охид, өсвөр, дунд эргэм насныхан эсхүл насанд хүрсэн этгээдийн эсрэг чиглэсэн бол....” оногдуулах шийтгэлийг нэмэгдүүлэхээр хуульчилсан байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улс НҮБ-д гишүүнээр элссэн нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрч, улмаар "Иргэний болон улс төрийн эрхийн тухай", "Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай" олон улсын пакт зэрэг хүний эрхийн талаарх гэрээ, конвенцоор хүний үндсэн эрх, эрх чөлөөг ямар нэгэн ялгаварлалгүйгээр энх тайвны цагт ч, зэвсэгт мөргөлдөөний үед ч хангаж мөрдөх үүрэгтэй байна.

Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 6 дахь удаагийн ээлжит тайланд Хүний эрхийн хорооноос гарсан дүгнэлттэй холбоотойгоор өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах шаардлагатай эсэхийг судлан үзвэл, манай улсад ялгаварлан гадуурхалт, эрх тэгш байдал, шударга ёсны талаар хууль, тогтоомжид тусгасан хэдий ч зохицуулагдаагүй үлдсэн болон засан сайжруулах шаардлагатай зарим асуудал байх тул, тус харилцааны эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэж үзэх үндэсгүй байна. УИХ болон ЗГ-ын тогтворгүй байдал, ажлын уялдаа, залгамж холбоо алдагдсантай холбоотой хүний эрхийг хангах ажлыг төрөөс зохион байгуулж буй нь хангалттай бус байна. УИХ, ЗГ-ын тогтоол, бусад журмаар зохицуулагдаж байсан харилцаа сүүлийн үед зөвхөн хуулиар

³⁹ https://www.dol.gov/oasam/regs/statutes/age_act.htm Сүүлд зочилсон: 2019-05-08

⁴⁰ Ian Brownlie, *Basic documents on Human rights*, II edition, Clarendon Press Oxford, 1981, P.382

⁴¹ LEY 1482 DE 2011 (noviembre 30), Сүүлд зочилсон: 2019-05-08, http://www.secretariasenado.gov.co/senado/basedoc/ley_1482_2011.html

зохицуулагдаж, хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар хүлээлгэх болсон нь зарим харилцаа зохицуулалтгүй орхигдох явдал үүссэн байна.

Иймд тусгайлан зохицуулсан, шинэлэг харилцааг зохицуулсан хууль шаардлагатай юм.

Судалгааны 3-р хэсэгт зардал, үр өгөөжийн харьцааг зорилгод хүрэх боломжтой харьцуулан судалсны үндсэн дээр дээрх хоёр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дагавар

Хувилбар 1-ийн хувьд иргэдэд тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдэж, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, эрх тэгш нөхцөл байдлыг хангах нэгдсэн тогтолцоотой болно. Ингэснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч иргэдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшилнэ.

Хувилбар 2-ын хувьд иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээний жишиг зардлыг тогтоож, хүний эрхийг хангах, хамгаалах олон тооны мэргэжлийн байгууллагаас сонгож үйлчлүүлэх, эрхээ хамгаалуулах, одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын чанар, хүртээмжийг сайжруулах боломж бүрдэнэ. Түүнчлэн улсын төсөвт үзүүлэх зардлын ачааллыг бага байлгах боломжтой.

Гарч болох сөрөг үр дагавар

Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ конвенцийн үзэл баримтлалд хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, шударга шүүхээр шүүлгэх, аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхээр хангагдах нь хүн бүрийн эдлэх эрх тул үүнийг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэхдээ хууль хоорондын уялдаа холбоог хангаагүйгээс сөрөг үр дагавар үүсэх магадлалтай гэж дүгнэсэн билээ.

Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр ялгаварлан гадуурхалтаас ангид эрх тэгш байх үндсэн зарчим хэрэгжих шалтгаан нөхцөл нь эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарладаг, нөгөө талаас хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын үйл ажиллагааны хүрээнд заавал удирдлага болох хууль зүйн эрх, үүрэг, хариуцлага гурав хүн бүрт адил тэгш үйлчилж байдаг.

Төрөөс хүний эрхийг хангах, хамгаалахад тохирох үүрэг, хариуцлагыг ногдуулдаг аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах нь эрх тэгш байх үндсэн зарчим бүрэн утгаараа хэрэгжих баталгаа бүрдэх учиртай.

Хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулан уялдуулахад бүрдэл хэсэг тус бүрээр дараах байдлаар авч үзэх саналтай байна:

- Хууль тогтоох болон бүх шатны гүйцэтгэх байгууллага;
- Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүх, прокурор, өмгөөлөх мэт хүний эрхийг хангах шууд үүрэг зорилго бүхий төрөлжсөн байгууллагууд;
- Нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг оролцуулан иргэний нийгмийн бүх байгууллага, хөдөлгөөн, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл;
- Бүх төрлийн бизнес эрхлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа;
- Хүний эрхийг хангах, хамгаалах ажлын алба, тэдгээртэй адилтгах хэлтэс, нэгж.

Тус байгууллагууд нь хүний эрхийг хангах, хамгаалах, аливаа төрлийн ялгаварлан гадуурхалт гарах байдлыг таслан зогсооход чиглэсэн нарийвчилсан зохицуулалтыг тусгаж

өгөх, бүрдэл хэсгийн чадавх, хүний эрхийг сахин биелүүлэх, үүрэг хариуцлагыг тухайлсан хуулийн зохицуулалттай нийцүүлэн тодорхойлох шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

- Ж.Амарсанаа. Хүний эрх /Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал/ Уб.,2000 он.
- Ж.Амарсанаа, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас, эргэцүүлэл, 2000 он, №7, 103 дахь тал.
- Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Уб., 2017 он. 56 дахь тал.
- Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх /харьцуулсан эрх зүй/ Уб., 1999 он.
- ХБНГУ-н Ханнс Зайделийн сан, Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2009 он, 98 дахь тал
- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он, 2 дахь тал.
- Францын 1789 оны “Хүний ба иргэний эрх чөлөөний тунхаглал”-аас
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл. Уб., 2017 он.
- Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн талаарх судалгаа, үр дагаварт хийсэн үнэлгээ. /2018 онд ХЗДХЯ-ны захиалга/.
- Эрх зүйн үзэл баримтлал: шинэ хандлага, Олон улсын бага хурлын илтгэлийн эмхэтгэл, Уб., 2012, 51 тал.
- Ф.Мартенс. Современное международное право цивилизованных народов. Т.1.СПб, 1882, с.327
- Michael J. Perry, *The Constitution, the Courts and Human rights*, Wiley Eastern Limited, 1982, P.62
- Ian Brownlie, *Basic documents on Human rights*, II edition, Claredon Press Oxford, 1981, P.382

Цахим эх сурвалж

- Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан.<http://nli.gov.mn/?p=4411> ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН, Уб., 2018 он. /сүүлд үзсэн 2019.06.11/
- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, 2018 оны үйл ажиллагааны тайлан, 18 дахь тал. <http://nhrcm.gov.mn/мэдээ/жил-хагас-жилийн-үйл-ажиллагааны-тайлан/>
- World Press Freedom Index, accessed April 1, 2019, <https://rsf.org/en/ranking/2018>
- Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг. /контент анализын судалгаа/ ХБНГУ-ын Фридрих-Эбертийн-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар. 2018 он.
- <http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/14785.pdf> /сүүлд үзсэн 2019.06.11/
- Монгол Улс нэгдсэн үндэстний байгууллагын гишүүн болсон нь. Түүний түүхэн ач холбогдол [file:///C:/Users/Turbayar/Downloads/374-Article%20Text-1515-1-10-20150105%20\(1\).pdf](file:///C:/Users/Turbayar/Downloads/374-Article%20Text-1515-1-10-20150105%20(1).pdf) <http://www.info.mn/news/5948.htm> /сүүлд үзсэн 2019.06.14/
- Жэйм Фитцжералд “EQVAZ RIGHTS TRUST” олон улсын байгууллагын дэд захирал. <https://www.youtube.com/watch?v=5HYI62ySPsk> /сүүлд үзсэн 2019.06.14/

- Богд хаант Монгол Улсын үед гаалийн түшмэл байсан С.Данзан <http://www.info.mn/news/5948.htm> /сүүлд үзсэн 2019.06.14/
- <http://hdr.undp.org/en/countries>
- Монгол Улсын НҮБ–д илгээсэн тайлангууд: <http://hdr.undp.org/en/countries/profiles/MNG>
- https://www.unicef.org/about/annualreport/files/Mongolia_2017_COAR.pdf
- НҮБ тус конвенцод нэгдсэн улс орнуудын илтгэл, тайлангууд: https://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/TBSearch.aspx?Lang=en&TreatyID=6&DocTypeID=27 /сүүлд үзсэн 2019.06.17/
- Европын Холбооны мэдэгдэл, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн №73 чуулган 3 дугаар хороо, 2018 /уг мэдэгдэлд Турк, Бүгд Найрамдах Макадони, Монтенегро, Серби, Албани, Босни ба Херцеговина, Украин, Молдав, Жеоржиа улсууд мөн нэгдэж буйгаа илэрхийлсэн/, сүүлд үзсэн 2019-03-22:
- https://eeas.europa.eu/delegations/un-new-york/52953/eu-statement-%E2%80%93-united-nations-3rd-committee-elimination-racism-racial-discrimination_en
- <https://www.gov.uk/guidance/equality-act-2010-guidance>
- ИБУИНВУ “Тэгш байдлын хууль” (2010), 13 дүгээр зүйл. <https://www.gov.uk/guidance/equality-act-2010-guidance>
- “References to particular strands of discrimination” https://www.antidiskriminierungsstelle.de/EN/TheAct/theAct_node.html
- Тэгш хандах тухай Ерөнхий хууль (2006), <http://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/77201/93329/F695840346/DEU77201.pdf>
- <https://www.legislation.gov.au/Details/C2019C00132>
- <https://www.aq.gov.au/RightsAndProtections/HumanRights/Pages/Australias-Anti-Discrimination-Law.aspx> ,
- (Title VII and Title II of the Civil Rights Act of 1964) Сүүлд зочилсон: 2019-06-14, <https://knowledge.leglobal.org/anti-discrimination-laws-in-usa/>
- https://www.dol.gov/oasam/regs/statutes/age_act.htm Сүүлд зочилсон: 2019-05-08,
- LEY 1482 DE 2011 (noviembre 30), Сүүлд зочилсон: 2019-05-08, <http://www.secretariasenado.gov.co/senado/basedoc/ley>

**ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨНИЙ УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ
ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалтыг арилгахад чиглэнэ.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах байдлыг хуулиар хориглох шаардлагыг тодотгох боломжтой.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол Олон Улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг зөрчөөгүй төдийгүй олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцнэ.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхалт аливаа байдлаар өртөж байсан хүмүүс мөн тэдний ар гэрийн хүмүүсийн саналыг авсан.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Аливаа хүн бүрийн тэгш байдлыг хангах, бүгдэд адил боломж хангагдана.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хангаж, хамгаалах механизм сайжирна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын Олон Улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцнэ.
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхсан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага оногдуулах саналыг дэвшүүлсэн.	
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.

3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үндэсний цөөнх, ТББ
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалтад өртөж буй иргэдийн эрх тэгш байх эрхийг хангахад чиглэсэн.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхалтад өртөж буй иргэд нийгмийн харилцаанд адил тэгш оролцох боломжийг хангахад чиглэсэн.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй харин тэдгээрийн тэгш байдлыг хангах.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хамгаалагч, ТББ, хүний эрхийг хангах төрийн үүрэг хүлээсэн алба хаагчид нэмэлт үүрэг хүлээнэ.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Жендэрийн тэгш байдлыг бүрдүүлсэн байна.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эрх тэгш боломжоор хангагдана.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Энэ чиглэлээр зохицуулалт агуулаагүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Аж ахуй нэгжид зардал үүсэх боломжтой.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Тодорхой нэмэлт зардал гарах боломжтой.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Шинээр ажлын байр нэмэгдэх боломжтой.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тодорхой арга хэмжээнд шаардагдах төсвийг улсын төсвөөс гаргах шаардлага гарч болно.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ажил эрхлэлтийн байдалд эерэг нөлөө үзүүлэх боломжтой.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон Улсын харилцаа	11.1.Монгол Улсын Олон Улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохирох орон тоо тодорхой хэмжээгээр нэмэгдэж болно
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ажлын байрны аюулгүй байдлын стандартад тодорхой хэмжээгээр нөлөөлөх боломжтой.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ажлын ажлын байрны стандарт боловсруулах шаардлага гарч болзошгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нь нөлөөлөх боломжтой.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй

5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Албан хаагчдыг хүний эрхийн сургалтад хамруулах шаардлага гарч болох юм.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 4)

Үзүүлэх нөлөө:	Үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар		1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч		2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах		3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц		4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол		5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Газрын ашиглалт		6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг		7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХЫН ЭСРЭГ ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХОЛБОГДОХ
ТҮҮВЭР СУДАЛГАА

(Хүснэгт 5)

Монгол Улсын хууль тогтоомжид “ялгаварлан” үгийн тусгагдсан байдал

№	Хууль /огноо/	Холбогдох зүйл, заалт
1.	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ /1992-1-13/	Арван дөрөвдүгээр зүйл. 1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. 2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна. Арван зургадугаар зүйл. 10/нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;
2.	АХМАД НАСТНЫ ТУХАЙ /2017-1-26/	5 дугаар зүйл. Ахмад настны эрхийг хангахад төрөөс баримтлах зарчим 5.1.1.нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах; 5.1.4.үл ялгаварлах; 6.10.Гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч нь ахмад настныг нийгмээс тусгаарлах, ялгаварлан гадуурхах, нийгмийн харилцаанд оролцоход нь саад учруулах, хязгаарлах, түүнийг хөгжих, асран сувилах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийхийг хориглоно.
3.	БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ /2017-07-06/	5 дугаар зүйл.Биеийн тамир, спортын үндсэн зарчим 5.1.4.спортыг ялгаварлан гадуурхалт, шударга бус өрсөлдөөнөөс ангид байлгах.
4.	БОЛОВСРОЛЫН ТУХАЙ /2006-07-06/	5 дугаар зүйл.Боловсролын үндсэн зарчим 5.1.Боловсролын үндсэн зарчим нь: 5.1.4.иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана; 44 дүгээр зүйл.Багшийн эрх, үүрэг 44.2.Багш дараахь үүрэгтэй: 44.2.4.суралцагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрийг нь хүндэтгэн хамгаалах; 44.2.6.суралцагчийн бие даасан байр суурь, үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;
5.	ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ /2017-2-02/	40.4.Тусламж үзүүлэгч тал дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 40.4.1.иргэдийг үндэс, угсаа, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах;
6.	ГЭР БҮЛИЙН ТУХАЙ /1999-6-11/	4 дүгээр зүйл. Гэрлэлт, гэр бүлийн харилцааны зарчим 4.1.Гэрлэлт нь тэгш эрх, сайн дурын харилцаан дээр үндэслэнэ. 4.2.Иргэнийг гэрлэхэд нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахыг хориглоно. 25 дугаар зүйл. Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах 25.1.Хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдэлнэ.

		25.2.Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн болон гэрлэгчдийн хэн нэгний нь дагавар хүүхдийг ялгаварлан гадуурхаж, эрх, ашиг сонирхлыг нь хохироохыг хориглон
7.	ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ /2016-12-22/	4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зарчим 4.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална: 4.1.1.хоширогчийн нэр төрийг хүндэтгэх, үл буруутгах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх; 28.3.Энэ хуулийн үйлчлэлд хамаарах этгээд хүүхэдтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, ялгаварлан гадуурхах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, заналхийлэх, хүч хэрэглэх, зодож шийтгэх, тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, үл хайхрах, хүүхдийн дэргэд архидан согтуурах, мансуурах, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно.
8.	ДОНОРЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2018-1-19/	12 дугаар зүйл.Донорт тавигдах шаардлага 12.2.Донорыг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.
9.	ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ /1994-7-7/	8 дугаар зүйл. Жагсаал, цуглаан болон өлсгөлөн зохион байгуулахыг хориглох 1. Дараахь зорилгоор жагсаал, цуглаан хийхийг хориглоно: 1/ дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа,хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах;
10.	ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ /2011-2-2/	Бүхэлдээ
11.	ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ /2017-5-18/	5 дугаар зүйл.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд баримтлах зарчим 5.1.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд дараахь зарчмыг баримтална: 5.1.1.үндэсний эв нэгдэл, шударга ёсыг дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх;
12.	ЗӨРЧЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-5-11/	6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих 8.Хүүхдийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан ялгаварлан гадуурхсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
13.	ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ /1995-4-17/	8 дугаар зүйл.Өргөдөл, гомдол гаргах зарчим 1.Өргөдөл, гомдол гаргагч өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль, бусад хуулийг зөрчих, бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироох, ялгаварлан гадуурхахыг уриалж болохгүй.
14.	МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2016-1-07/	6.3.Монголын улаан загалмай нийгэмлэг нь зорилго, чиг үүрэгтээ хамаарах дараах үйл ажиллагааг эрхэлнэ: 6.3.3.гамшиг, осол, зэвсэгт мөргөлдөөн, нийтэд учирсан гамшигт байдлын үед хэнийг ч үл ялгаварлан анхны тусламж, нийгмийн сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;

15.	ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ /2005-1-27/	8 дугаар зүйл.Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого 8.3.Олон нийтийн радио, телевизээр харгислал, ялгаварлан гадуурхал, дайн, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан, иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан агуулгатай нэвтрүүлэг бэлтгэж түгээхийг хориглоно.
16.	ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ /1995-11-14/	17 дугаар зүйл.Онцгой арга хэмжээг тогтоох, хэрэглэх хүрээ заагийн хязгаарлалт 1.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээ зааг нь бий болсон онцгой нөхцөлийн шаардлага, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгт нийцэж байхаас гадна хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байвал зохино.
17.	СОЁЛЫН ТУХАЙ /1996-4-11/	19 дүгээр зүйл. Соёлын хүрээнд төрийн болон бусад байгууллага, иргэнээс явуулах үйл ажиллагаанд тавих хязгаарлалт 2. Угсаатан ястны соёлыг ялгаварлан гадуурхах, хавчин хязгаарлахыг хориглоно.
18.	СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ /2013-1-3/	6 дугаар зүйл.Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаарх иргэн, хуулийн этгээдийн үүрэг 6.1.Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ: 6.2.2.сэтгэцийн эмгэгтэй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохыг цээрлэх;
19.	ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ /1993-11-11/	3 дугаар зүйл.Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө 3.Иргэдийг шашин шүтлэгийн ялгаа болон шашин шүтэх, эс шүтэх байдлаар нь ялгаварлан гадуурхах, доромжлох, хагалан бутаргах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
20.	ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-12-07/	37 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг 37.1.Төрийн жинхэнэ албан хаагч дараахь нийтлэг үүрэг хүлээнэ: 37.1.12.төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх 39 дүгээр зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл 39.1.12.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.5, 4.1.6-д заасан хэлбэрээр иргэнийг ялгаварлан гадуурхах;
21.	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ /1997-1-31/	5 дугаар зүйл.Төрийн бус байгууллага байгуулах, оролцох эрх 4.Төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө хүнийг ялгаварлан гадуурхах, эрх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.
22.	УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2005-1-28/	4 дүгээр зүйл.Намын тухай ойлголт 4.2.Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг үймүүлэх, айлган сүрдүүлэх, аллага, хядлага үйлдэх, яс үндэс, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгоор, түүнчлэн шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист нам байгуулахыг хориглоно. 5 дугаар зүйл.Намын үйл ажиллагааны зарчим

		<p>5.1.3.гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох;</p> <p>23.2.Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, яс, үндэс, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулсан буюу шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист намын хэлбэрт шилжсэн бол Улсын дээд шүүх намыг тараах тухай шийдвэр гаргаж, уг намыг энэ хуулийн 23.1-д заасан хугацаанд улсын бүртгэлээс хасч, нийтэд мэдээлнэ.</p>
23.	УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ /1998-1-2/	<p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо</p> <p>3.1.2.“улс төрийн хэлмэгдүүлэлт” гэж хүнийг нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан нам, төр, нийгэмд аюултай этгээд гэж тооцож, улс төрийн буюу төрийн эсрэг гэх гэмт хэрэгт хууль бусаар холбогдуулж, шүүх тусгай, онцгой бүрэн эрхт комиссын болон нам, төрийн бусад байгууллагын шийдвэрээр баривчлан мөрдөх, эрүүгийн ял шийтгэл эдлүүлэх, шүүхээс гадуур нутаг зааж суулгах, хууль бусаар эрх, эрх чөлөөг нь хязгаарлах, хасах замаар амь нас, эрүүл мэнд, нэр төр, сэтгэл санаа, эд хөрөнгийн хохирол учруулсан бөгөөд зохиомол хэрэг, гүтгэлэгт үндэслэсэн албадлагын арга хэмжээг;</p>
24.	ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН ЭРХИЙН ТУХАЙ /1991-4-19/	<p>3 дугаар зүйл.Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх</p> <p>3.Үйлдвэрчний эвлэлийн гишүүн мөн эсэхтэй холбогдуулан иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах буюу тэднийг ялгаварлан гадуурхахыг хориглоно.</p>
25.	ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУХАЙ /2011-10-27/	<p>4 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зарчим</p> <p>4.1.Хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:</p> <p>4.1.7.ялгаварлан гадуурхахгүй байх;</p>
26.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ /2016-2-05/	<p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</p> <p>4.1.2.“хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг;</p> <p>5 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим</p> <p>5.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад дараахь зарчмыг баримтална:</p> <p>5.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих;</p> <p>Хоёрдугаар бүлэг: Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх</p> <p>6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах</p> <p>6.1.Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.</p> <p>6.2.Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байх, бүрдүүлэхээс татгалзах, нийгмийн үйлчилгээг бусдын адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах</p>

		<p>төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхгүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ.</p> <p>6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхгүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:</p> <p>Бусад.</p>
27.	ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ /1999-5-14/	<p>7 дугаар зүйл.Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох</p> <p>7.1.Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй.</p> <p>7.2.Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нас, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно.</p>
28.	ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ /2012-01-19/	<p>4 дүгээр зүйл.Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зарчим</p> <p>4.1.Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаанд дараах зарчмыг удирдлага болгоно:</p> <p>4.1.3.Ялгаварлан гадуурхахгүй байх;</p>
29.	ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУСЫН ХАЛДВАР, ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛООС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2012-12-13/	<p>11 дүгээр зүйл.Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүний эрхийг хамгаалах</p> <p>11.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүний эрх, эрх чөлөөг хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой гэсэн үндэслэлээр хязгаарлахыг хориглоно.</p> <p>11.2.Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүнийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг хориглоно.</p>
30.	ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ /2016-2-05/	<p>4 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн үндсэн зарчим</p> <p>4.1.Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь зарчмыг баримтална:</p> <p>4.1.1.хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх;</p>
31.	ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2012-5-22/	<p>6 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдоход хориглох зүйл</p> <p>6.2.Иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулахдаа үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.</p>
32.	ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /2015-12-03/	<p>14.1 дүгээр зүйл.Ялгаварлан гадуурхах</p> <p>1.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</p> <p>19.9 дүгээр зүйл.Үндэсний эв нэгдлийг бусниулах</p> <p>1.Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан, хүчирхийлсэн, эрхийг нь хязгаарласан, давуу байдал тогтоосон үйлдлийг зохион байгуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим</p> <p>2.Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн</p>

		ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй.
33.	ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-5-18/	1.12 дугаар зүйл.Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх 1.Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. 35.18 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах 1.Шүүх хуралдааны турш энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авахад гэрч, хохирогчийн хувийн байдал, тухайн гэмт хэргийн нөхцөл байдал, ялгаварлан гадуурхах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн зэргийг харгалзана.
34.	ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ /2011-5-5/	4 дүгээр зүйл.Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчим 4.1.Төрөөс хүн амын эрүүл мэндийн талаар дараах бодлогыг хэрэгжүүлнэ: 4.1.2.хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх;
УИХ-ЫН ТОГТООЛ		
1.	Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр /2003-10-24 Дугаар 41/	1992 оны Үндсэн хуульд Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш, эрх зүйн этгээд байх, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхахгүй байх зарчим, хүний салшгүй эрхүүдийг баталгаажуулсан юм.
2.	Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 02 тоот дүгнэлтийн тухай /1998-4-17 Дугаар 38/	3.Тухайн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлснээс их бол 40 хувиар.”; гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтыг, Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Иргэд... өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй гэсэн заалтыг тус тус зөрчжээ” гэж үзсэн Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 02 тоот дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
3.	Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай /2010-04-22 Дугаар 19/	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 01 дүгээр дүгнэлтийн “Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт “60-аас дээш настай,...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... нас, ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно”, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна” гэснийг хүлээн зөвшөөрсүгэй.
4.	Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 07 дугаар дүгнэлтийн тухай	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

	/2014-04-10 Дугаар29 /	<p>1.“Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл сэтгэцийн өвчтэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан, эсхүл жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татсан, эсхүл дарамт шахалт үзүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасны “... эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, ... -ийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ...ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын “... тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ...” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.</p>
5.	Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 03 дугаар дүгнэлтийн тухай /2014-04-10 Дугаар 29/	<p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:</p> <p>1.“Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.7 дахь хэсгийн “... Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.”, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн “... Давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй.”, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй. 2.Энэ тогтоолыг 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.</p>
1.	ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ /НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө/ /2016-4-11 Дугаар 204/	<p>108.44. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн үүрэг, хариуцлагын талаарх нийгмийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, ялгаварлан гадуурхах уламжлалт зан үйлийг халах арга хэмжээнийхээ үр нөлөөг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлтаа нэмэгдүүлэх (Словени)</p> <p>108.154. Бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг зохицуулсан, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад насны хүмүүсийн эрхийг хамгаалах тодорхой хууль батлах (Турк)</p> <p>108.86. Гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг халах чиглэлээр илүү хүчин чармайлт гаргах,</p> <p>108.20. Ялгаварлан гадуурхахтай тэмцэх цогц хууль тогтоомжийг батлах, ийнхүү батлах хууль тогтоомж, эсхүл одоо байгаа хуулиар</p>

		<p>тогтоосон тэгш байдлыг бодит амьдралд баталгаажуулах алхмыг авч хэрэгжүүлэх (Ирланд)</p> <p>108.41. Аливаа шалтгаанаар ялгаварлан гадуурхахтай тэмцэх шинэ хууль тогтоомжийг батлах (Уругвай)</p> <p>108.50. Арьс үндсээр ялгаварлан гадуурхахыг өдөөн хатгасан үзэн ядах үг хэлэх үйлдэлтэй болон үүнээс улбаатай хүчирхийлэлтэй тэмцэх (Хятад)</p> <p>108.42. Ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийн эсрэг, түүний дотор хохирогчдын эрхийг хамгаалсан цогц хууль батлах (Бүгд Найрамдах Чех Улс)</p> <p>108.53. Бэлгийн чиг баримжаа, эсхүл хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэртэй тэмцэх (Франц)</p> <p>108.61. Өмнөх удаа зөвлөмж болгож байсанчлан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг, тэр дундаа хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолтой гэсэн үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг эрс хориглох, гарахаас урьдчилан сэргийлэх, шийтгэх, болон устгах зорилго бүхий хууль тогтоомжийг батлах, үр нөлөөтэй, шуурхай арга хэмжээ авах (Мексик)</p> <p>108.32. Парисын зарчимд нийцүүлэх зорилгоор Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагааг сайжруулах, ялгаварлан гадуурхалтын эсрэг үр нөлөөтэй тэмцэх эрх зүйн орчинг бэхжүүлэх (Нигери)</p> <p>108.51. Гэр хорооллын дүүргүүдэд амьдарч байгаа хүмүүсийг шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх үр нөлөөтэй арга хэмжээнүүдийг авах (Швед)</p>
2.	<p>НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛӨӨС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖҮҮДИЙГ 2011-2014 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ /2011-5-18 Дугаар 159/</p>	<p>11/Үндэсний хууль тогтоомжийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх, олон улсын стандарт, хэм хэмжээг үр дүнтэй хэрэглэх зорилгоор шүүгчид болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулах</p> <p>19/ Арьс өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын Конвенцид тусгагдсан хувь хүний гомдлыг хянан шийдвэрлэх механизмыг нэвтрүүлэх боломжийг судлах</p> <p>31/ Эмэгтэйчүүдэд адил тэгш боломж олгоход чиглэсэн бодлого боловсруулах, тэгш хөдөлмөр эрхлэлтийг баталгаажуулах</p> <p>41/ Бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаагаар алагчлахыг хатуу хориглосон хууль тогтоомж боловсруулан, хэрэгжилтийг хангах</p> <p>47/ ХДХВ/ДОХ болон аливаа бусад байдлаар алагчлах явдлыг хориглох, устгах, түүнээс урьдчилан сэргийлэх, ийм хэрэг үйлдэгчдийг шийтгэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төсөл боловсруулах, шуурхай, үр нөлөөтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх</p> <p>52/ Хүний эрхийн боловсрол, мэдээллийг олон нийтэд түгээх замаар "ЛГБТ" хүмүүсийг алагчлах үзлийг арилгах, тэдний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хангах гэх зэрэг хүний эрхийг хангах хамгаалахад чиглэсэн ажилуудыг төлөвлөсөн байна.</p>
3.	<p>ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ /2019-03-21 Дугаар 111/</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулах орон тоог аж ахуйн нэгж байгууллагын нийт ажиллагчдын 25 хүн тутамд 1 гэж тооцохдоо ажиллуулаагүй тохиолдолд сар дутамд Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймагт тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн хэмжээгээр, бусад аймагт тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн 60 хувиар төлбөр авч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэхийг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосон байна.</p>

(Хүснэгт 6)

Монгол Улсын хууль тогтоомжид “үзэл бодол” үгийн тусгагдсан байдал

№	Хууль	Холбогдох зүйл, заалт
1.	АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ /2006-07-06/	28 дугаар зүйл. Улс төрийн баталгаа 28.2. Авлигатай тэмцэх газрын албан хаагч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албандаа хүндэтгэлтэй хандана.
2.	БОЛОВСРОЛЫН ТУХАЙ /2006-07-06/	5 дугаар зүйл. Боловсролын үндсэн зарчим 5.1. Боловсролын үндсэн зарчим нь: 5.1.4. иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана; 44 дүгээр зүйл. Багшийн эрх, үүрэг 44.2. Багш дараахь үүрэгтэй: 44.2.6. суралцагчийн бие даасан байр суурь, үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;
3.	ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-02-02/	40 дүгээр зүйл. Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт 40.4. Тусламж үзүүлэгч тал дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 40.4.1. иргэдийг үндэс, угсаа, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах;
4.	ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ /1997-12-19/	АЖЛЫН 5 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил явуулах ерөнхий нөхцөл Хувь хүний иргэний харьяалал, яс үндэс, хүйс, нийгмийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, ажил, албан тушаалын байдал нь түүний хувьд хуульд заасан үндэслэл журмын дагуу гүйцэтгэх ажил явуулахад саад болохгүй. 14 дүгээр зүйл. Туслагч, туслах ажилтан ажиллуулах 14.1. Гүйцэтгэх байгууллага нь эрх зүйн чадамжтай энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад хүнийг өөрийн нь зөвшөөрснөөр иргэний харьяалал, үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан туслагч, туслах ажилтнаар ажиллуулж болно.
5.	ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ /1998-5-15/	26 дугаар зүйл. Хүний эрх, эрх чөлөөний баталгаа 26.1. Дайны байдлын үеийн үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлахыг хориглоно.
6.	ДОНОРЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2018-1-19/	12 дугаар зүйл. Донорт тавигдах шаардлага 12.1. Донор нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг аврахад зориулан цус, эс, эд, эрхтнээ өгөхдөө ашгийн төлөө бус, авлагагүй, сайн дурын байна. 12.2. Донорыг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.
7.	ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ /1994-7-7/	Бүхэлдээ
8.	ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ /2011-2-2/	5 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчим, бодлого

		<p>5.1.Жендэрийн эрх тэгш байдал дараахь үндсэн зарчимд тулгуурлана:</p> <p>5.1.2.ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх;</p>
9.	ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ /2017-05-18/	<p>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</p> <p>4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>4.1.3.“залуучуудын оролцоо” гэж залуучуудын улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил, шийдвэр гаргах түвшинд үзэл бодлоо илэрхийлэх, оролцох үйл явцыг;</p> <p>5 дугаар зүйл.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд баримтлах зарчим</p> <p>5.1.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд дараахь зарчмыг баримтална:</p> <p>5.1.3.залуучуудын үнэлэмжийг нэмэгдүүлж, тэдний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах.</p>
10.	ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ /2002-5-30/	<p>7 дугаар зүйл.Хууль бус зар сурталчилгаа</p> <p>7.4.Дараахь зар сурталчилгааг ёс суртахуунд үл нийцсэнд тооцно:</p> <p>7.4.5.үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, нас, хүйс, мэргэжил боловсрол, шашин шүтлэг, үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг, харьцуулалт, дүрслэл зэргийг ашигласан;</p>
11.	ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2016-2-04/	<p>4 дүгээр зүйл. Шүүхийн өмнө эрх тэгш байх</p> <p>4.1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэх/ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана</p>
12.	ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ /2017-02-09/	<p>5 дугаар зүйл. Зөвлөлдөх санал асуулгын зарчим</p> <p>5.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийг удирдлага болгон зөвлөлдөх санал асуулгыг дараахь зарчмыг баримтлан явуулна:</p> <p>5.1.1.хууль дээдлэх;</p> <p>5.1.2.иргэний бодитой, шууд оролцоог хангах;</p> <p>5.1.3.иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах;</p>
13.	ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ /2002-1-10/	<p>4 дүгээр зүйл.Шүүхийн өмнө эрх тэгш байх</p> <p>4.1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэх/ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана.</p>
14.	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ /1993-6-5/	<p>15 дугаар зүйл.Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрх</p> <p>4.Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.</p>

15.	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ /1992-01-13/	<p>Арван дөрөвдүгээр зүйл. 1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. 2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.</p> <p>Арван зургадугаар зүйл. Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 10/нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно; 16/итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;</p> <p>Арван наймдугаар зүйл. 4.Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно.</p> <p>Арван есдүгээр зүйл. 1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. 2.Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө. 3.Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.</p>
16.	МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ /2000-12-07/	<p>3 дугаар зүйл. Комисс, түүний үйл ажиллагааны зарчим 3.1. Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих байгууллага мөн.</p> <p>21 дүгээр зүйл. Улс төрийн баталгаа 21.2. Комиссын гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.</p>
17.	МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2016-1-07/	<p>6 дугаар зүйл. Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго, чиг үүрэг 6.1.Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго нь зэвсэгт мөргөлдөөн ба нийтэд учирсан гамшигт байдлын үед хүн амд эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн тусламж үзүүлэхээс гадна хүнийг зовлон зүдгүүрт өртөхөөс сэргийлэх, учирсан зовлон зүдгүүрийг</p>

		хөнгөвчлөх, шударга ёсны зарчимд үндэслэн хүнийг яс үндэс, иргэний харьяалал, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, бэлгийн чиг хандлага, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, боловсролоос үл хамааран хүний аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүмүүнлэг ёсыг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, хүмүүс хоорондын ойлголцол, нөхөрлөл, хамтын ажиллагааг дэмжих, энх тайвныг бэхжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулахад оршино.
18.	НИЙТИЙН СОНСГОЛЫН ТУХАЙ /2015-07-08/	3 дугаар зүйл.Үндсэн зарчим 3.1.Нийтийн сонсголыг зохион байгуулахад ардчилсан ёс, хууль дээдлэх, талуудын оролцоог тэгш хангах, иргэний мэдэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах, үр нөлөөтэй байх зарчмыг удирдлага болгоно
19.	ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ /2005-1-27/	8 дугаар зүйл.Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого 8.2.Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ дараахь бодлого баримтална: 8.2.1.ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хүндэтгэх; 8.2.2.улс төр, шашин, нийгэм, эдийн засгийн олон ургальч үзэл бодлыг хүндэтгэж, тэдгээрийг тэгш илэрхийлэх;
20.	ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ /1995-11-14/	17 дугаар зүйл.Онцгой арга хэмжээг тогтоох, хэрэглэх хүрээ заагийн хязгаарлалт 1.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээ зааг нь бий болсон онцгой нөхцөлийн шаардлага, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгт нийцэж байхаас гадна хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байвал зохино.
21.	ПРОКУРОРЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-06-09/	61 дүгээр зүйл.Улс төрийн баталгаа 61.1.Прокурор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.
22.	СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ /2006-01-12/	11 дүгээр зүйл. Хорооны гишүүний бүрэн эрхийн баталгаа 11.11.Хорооны гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ хашиж буй төрийн албан тушаалдаа хүндэтгэлтэй хандана.
23.	СОНГУУЛИЙН ТУХАЙ /2015-12-25/	11 дүгээр зүйл.Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрх 11.1.Сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй. 76 дугаар зүйл.Сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагааны баталгаа 76.1.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь энэ хуульд тусгайлан зааснаас гадна доор дурдсан эрх эдэлнэ: 76.1.2.үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
24.	СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ /1999-7-1/	5 дугаар зүйл.Баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийн эрх зүйн байдал 5.3.Хоригдсон этгээдийн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоос үл хамааран энэ хууль нэгэн адил үйлчилнэ.

25.	ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-12-07/	31 дүгээр зүйл.Хориглох зүйл 31.4.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяаллаар ялгаварлаж үл болно.
26.	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ /1997-1-31/	4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёо Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 1/"төрийн бус байгууллага" гэж иргэд, төрийн байгууллага / хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг; 5 дугаар зүйл.Төрийн бус байгууллага байгуулах, оролцох эрх 1.Монгол улсын иргэн, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс дангаараа буюу хамтран төрийн бус байгууллага байгуулах эрхтэй.
27.	УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2005-1-28/	4 дүгээр зүйл.Намын тухай ойлголт 4.1.Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн. 18 дугаар зүйл.Гишүүний татвар, намд өгөх хандив 18.2.Гишүүн, дэмжигчид үзэл бодол, итгэл үнэмшлээрээ намыг дэмжин хандив өргөж болно. Хандивыг зөвхөн тухайн шатны намын байгууллагын дансаар дамжуулж авна.
28.	УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ /1998-01-02/	3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.2."улс төрийн хэлмэгдүүлэлт" гэж хүнийг нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан нам, төр, нийгэмд аюултай этгээд гэж тооцож, улс төрийн буюу төрийн эсрэг гэх гэмт хэрэгт хууль бусаар холбогдуулж, шүүх тусгай, онцгой бүрэн эрхт комиссын болон нам, төрийн бусад байгууллагын шийдвэрээр баривчлан мөрдөх, эрүүгийн ял шийтгэл эдлүүлэх, шүүхээс гадуур нутаг зааж суулгах, хууль бусаар эрх, эрх чөлөөг нь хязгаарлах, хасах замаар амь нас, эрүүл мэнд, нэр төр, сэтгэл санаа, эд хөрөнгийн хохирол учруулсан бөгөөд зохиомол хэрэг, гүтгэлэгт үндэслэсэн албадлагын арга хэмжээг;
29.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ /2016-02-05/	28 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх 28.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой аливаа бодлого, шийдвэрийг гаргах явцад тэднийг үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангана.
30.	ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2011-06-17/	4 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зарчим, төрийн бодлогын чиглэл 4.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд дараах зарчим баримтална: 4.1.1.иргэнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, хөрөнгө чинээ, боловсрол, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь үл ялгаварлах;
31.	ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ /1999-05-14/	2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

		<p><u>Хэвлэх</u> 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.14."албадан хөдөлмөр" гэж хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтад оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил, үүргийг; 7 дугаар зүйл.Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох 7.1.Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй. 7.2.Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нас, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно. <i>/Энэ хэсэгт 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i> 7.4.Иргэнийг ажилд авахад эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд түүний хувийн амьдрал, үзэл бодолтой холбоотой, гэрлэлтийн байдал, намын харьяалал, шүтдэг шашных нь тухай болон жирэмсэн эсэх талаар асуулт тавьж болохгүй.</p>
32.	ХҮҮХДИЙН ТУХАЙ /2016-02-05/ ЭРХИЙН	<p>4 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн үндсэн зарчим 4.1.Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь зарчмыг баримтална: 4.1.3.хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах; 5 дугаар зүйл. Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх 5.3.Хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай үзэл бодол, саналаа илэрхийлэх эрхтэй. 6 дугаар зүйл. Хүүхдийн хөгжих эрх 6.1.Хүүхдийн бие махбодь, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараахь эрх эдэлнэ: 6.1.5.хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах;</p>
33.	ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ /1998-08-28/	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино. бүхэлдээ</p>
34.	ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-02-09/	<p>22 дугаар зүйл. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага 22.1.Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй. 84 дүгээр зүйл. Улс төрийн баталгаа</p>

		<p>84.3.Цагдаагийн алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандана.</p> <p>84.5.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно.</p>
35.	ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ /2016-09-01/	<p>4 дүгээр зүйл. Иргэний цэргийн үүрэг</p> <p>4.2.Монгол Улсын иргэн нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр цэргийн үүрэг хүлээнэ.</p>
36.	ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-06-09/	<p>7 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага</p> <p>7.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно.</p>
37.	ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/ /2015-12-03/	<p>1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим</p> <p>2.Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй.</p> <p>1.4 дүгээр зүйл.Гэм буруугийн зарчим</p> <p>4.Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.</p> <p>10.1 дүгээр зүйл.Хүнийг алах</p> <p>2.14.үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.</p> <p>14.3 дугаар зүйл.Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах</p> <p>1.Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</p> <p><i>/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>19.9 дүгээр зүйл.Үндэсний эв нэгдлийг бусниулах</p> <p>1.Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан, хүчирхийлсэн, эрхийг нь хязгаарласан, давуу байдал тогтоосон</p>

		<p>үйлдлийг зохион байгуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>19.14 дүгээр зүйл.Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх -Үзэл бодол, улс төрийн, шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгигдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад орогнох эрх олж авахын тулд Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.</p>
38.	<p>ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-05-18/</p>	<p>1.12 дугаар зүйл.Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх 1.Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.</p>
Улсын Их Хурлын тогтоол		
1.	<p>УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ БОДЛООР НЬ ЯЛГАВАРЛАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ АЖЛААС НЬ ХАЛАХ, ӨӨРЧЛӨХ АЛДАА ЗАВХАРЛЫГ ЗОГСООХ ТУХАЙ ТОГТООЛЫН ТӨСӨЛ БУЦААХ /2002-05-16/ Дугаар 17</p>	<p>2000 оны Улсын Их Хурлын сонгуулиас хойш улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан төрийн албан хаагчдыг ажлаас нь халах, өөрчлөх алдаа завхрал гарсан гэж үзэх үндэслэл байхгүй тул Улсын Их Хурлын гишүүн Л.Гүндалай, Ж.Наранцацралт нарын өргөн мэдүүлсэн “Улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан төрийн албан хаагчдыг ажлаас нь халах, өөрчлөх алдаа завхарлыг зогсоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг төсөл санаачлагчид нь буцаасугай.</p>
2.	<p>ЦАХИМ БОДЛОГЫН ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ /2018-05-24/ Дугаар 38</p>	<p>1.Төрийн алба, үйлчилгээг шуурхай, ил тод, хэмнэлттэй болгох, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, системийг сайжруулах, иргэний мэдээлэл авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө болон түүний хувийн мэдээллийн өгөгдлийн нууцыг хамгаалах, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний мэдээллийн дэд бүтцийг хамгаалах чадавх бий болгох, энэ чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, цахим бодлогын асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий Цахим бодлогын түр хороог дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай: /нийт 25 гишүүн/</p>
3.	<p>МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БАТЛАХ ТУХАЙ /2010-7-15/ Дугаар 48</p>	<p>Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар бүлгийн 3.6.4.1 дэх хэсэгт “Хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түүгээр эрх, эрх чөлөөг хангах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандах боломжийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмжтэй байдал хангагддаг.”</p>

(Хүснэгт 7)

Монгол Улсын хуулиудад “шударга ёс” тусгагдсан байдал

№	Хууль /огноо/	Холбогдох зүйл, заалт
1.	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ /1992/	<p>Монголын ард түмэн бид: ...шударга ёс... эрхэмлэн дээдэлж... эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.</p> <p>Нэгдүгээр зүйл.</p> <p>2. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.</p> <p>Арван хоёрдугаар зүйл.</p> <p>2. Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.</p> <p>Арван наймдугаар зүйл.</p> <p>4. Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно.</p>
2.	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ /2006/	<p>3 дугаар зүйл. Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчим</p> <p>3.1.Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчим бол Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ёсоор ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал мөн.</p>
3.	МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ /2012/	<p>4 дүгээр зүйл.Шүүхийн эрхэм зорилго</p> <p>4.1.3.хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх;</p> <p>8 дугаар зүйл.Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх</p> <p>8.4.Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ ил тод байдал, шударга ёс, олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмын дагуу оролцуулах бөгөөд иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.</p>
4.	МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2004/	<p>4 дүгээр зүйл. Яамны үйл ажиллагааны зарчим</p> <p>4.1.Яамны үйл ажиллагааны үндсэн зарчим нь ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал мөн.</p>
5.	ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ /2017/	<p>7 дугаар зүйл.Төрийн албаны зарчим</p> <p>7.1.Төрийн албанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:</p>
6.	ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2012/	<p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.1.шүүгч гэж хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдон, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг сахиулан хамгаалахаар тангараг өргөн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэнийг;</p> <p>4 дүгээр зүйл.Шүүгчид тавих болзол, шаардлага</p> <p>4.1.Шүүгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол болон дараах шаардлагыг хангасан байна:</p>

		<p>4.1.5.мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан, шударга ёсыг эрхэмлэдэг, хүний эрхийг дээдлэх, бусдын нөлөөнд автахгүй, бие даасан шийдвэр гаргах чадвартай; 16 дугаар зүйл.Шүүгчийн тангараг, түүнийг өргөх журам</p> <p>16.1.Шүүгч томилогдсон өдрөөсөө хойш 30 хоногийн дотор хамт олон болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийн өмнө “Шүүгч би шүүх эрх мэдлийн ариун журамт үүрэг, Монгол Улсын Үндсэн хуульт байгуулал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж хэрэг, маргааныг хэнээс ч хараат бус, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйг чанд сахиж явахаа ард түмэндээ батлан тангараглая. Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал шүүгчийн албан тушаалаас нэн даруй огцорч хуульд заасан хариуцлага хүлээнэ.” гэж Төрийн сүлдэнд тангараг өргөнө.</p> <p>31 дүгээр зүйл.Шүүгчид хүлээлгэх хариуцлага</p> <p>31.1.Шүүгч зөвхөн хуульд захирагдах, шударга ёсны зарчим болон шүүгчийн ёс зүйг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн бол холбогдох сахилгын болон хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.</p>
7.	ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2012/	<p>6 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим</p> <p>6.2.Хуульч нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, шударга ёсыг хангана.</p> <p>7 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн шалгалт</p> <p>7.2.Хуульчийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд тэгш эрх, шударга ёсыг хангах, ил тод байх, хууль дээдлэх, олон нийтийн итгэлийг даах, хараат бус байх зарчмыг баримтална.</p> <p>23 дугаар зүйл.Хуульчийн тангараг</p> <p>23.1.Хуульч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор “Хуульч би Монгол Улсын Үндсэн хуулийг даган мөрдөж, хуульчийн үүрэг, мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг чанд сахиж, шударга ёсыг хамгаалагчийн хувьд иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн, тууштай хамгаалахаа батлан тангаргалъя. Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ” гэж Хуульчдын холбоонд тангараг өргөнө.</p> <p>56 дугаар зүйл.Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо</p> <p>56.3.Хуульчдын эрхийг хамгаалах хороо нь хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тийм үйл ажиллагааг дэмжих замаар хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангах чиг үүрэгтэй байна.</p>
8.	НОТАРИАТЫН ТУХАЙ /2011/	<p>3 дугаар зүйл.Нотариатын зарчим</p> <p>3.1.4.шударга ёсыг сахих;</p>
9.	ГАЗРЫН ТУХАЙ /2002/	<p>4 дүгээр зүйл.Төрөөс газрын талаар баримтлах зарчим</p> <p>4.1.3.газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах;</p>
10.	ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ /1997/	<p>4 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын зарчим</p> <p>Гүйцэтгэх ажилд үндэсний болон нийгэм, төр, иргэний аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх, шударга ёс, тэгш байдал, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шуурхай, тасралтгүй байх, нууц хамгаалах зарчмыг удирдлага болгоно.</p>
11.	ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ /2017/	<p>5 дугаар зүйл.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд баримтлах зарчим</p> <p>5.1.1.үндэсний эв нэгдэл, шударга ёсыг дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх;</p>
12.	ЗӨРЧЛИЙН ТУХАЙ	1.1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

	/2017/	<p>1.Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.</p> <p>1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим</p> <p>1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна.</p> <p>2.Энэ хуульд заасан зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна.</p> <p>3.1 дүгээр зүйл.Шийтгэл оногдуулах үндэслэл</p> <p>1.Шийтгэлийн зорилго нь хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино.</p>
13.	ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /2015/	<p>1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим</p> <p>1.Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.</p> <p><i>/Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i></p> <p>2.Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй.</p> <p>3.Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй.</p> <p><i>/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>4.Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.</p> <p><i>/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>5.Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна.</p> <p>9.7 дугаар зүйл.Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага гарцаагүй байх</p> <p>3.Хуулийн этгээдэд энэ зүйлийн 1.3-т зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах боломжгүй, шударга ёсны зарчимд нийцэхгүй бол шүүгч гэмт хэрэг үйлдэгдэх үед тухайн гэмт хэрэгт холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж байсан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>19.14 дүгээр зүйл.Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх</p> <p>1.Монгол Улсад орох, гарах хил нэвтрэх эрхийн баримт бичиггүйгээр, эсхүл хуурамч баримт бичгээр, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын хилийг нэвтэрсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>Тайлбар: -Үзэл бодол, улс төрийн, шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгигдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад орогнох эрх олж авахын тулд Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.</p>
14.	ИРГЭНИЙ ХУУЛЬ	193 дугаар зүйл. Үүргийн гүйцэтгэлийг тодорхойлох

	/2002/	<p>193.1.Үүрэг гүйцэтгэх арга, хэлбэр, журмыг гэрээний аль нэг тал буюу гуравдагч этгээд тодорхойлсон нь нөгөө талд буюу талуудад эргэлзээ төрүүлэхээр бол шударга ёсны зарчимд нийцүүлэн харилцан хүсэл зоригоо илэрхийлэх замаар шийдвэрлэнэ.</p> <p>193.2.Үүрэг гүйцэтгэх арга, хэлбэр, журмыг тодорхойлсон нь шударга ёсны зарчимд нийцээгүй, эсхүл үүргийн гүйцэтгэлийг тодорхойлохыг хэт удаашруулж байна гэж аль нэг тал нь үзвэл арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэхээр хандах эрхтэй.</p> <p>202 дугаар зүйл. Стандарт нөхцөл хүчин төгөлдөр бус байх</p> <p>202.1.Стандарт нөхцөлийг гэрээнд тусгасан ч тэр нь харилцан итгэлцэл, шударга ёсны зарчимд харш, уг нөхцөлийг хүлээн зөвшөөрөгч нөгөө талдаа хохиролтой бол уг нөхцөл хүчин төгөлдөр бус байна. Энэ тохиолдолд стандарт нөхцөлийг гэрээнд тусгах болсон нөхцөл байдал, талуудын ашиг сонирхол болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ.</p> <p>488 дугаар зүйл. Дундын өмчийг ашиглах, удирдах</p> <p>488.2.Олонхийн шийдвэр буюу хэлцлээр өөрөөр тогтоогүй бол дундаа хэсгээр өмчлөгч бүр шударга ёсны дагуу бусад өмчлөгчдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглалт болон удирдлагын талаар шаардлага гаргах эрхтэй.</p>
15.	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ /1993/	<p>15 дугаар зүйл.Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрх</p> <p>4.Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.</p>
16.	МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ /2006/	<p>8 дугаар зүйл. Удирдлагын үндсэн зарчим</p> <p>8.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална.</p>
17.	ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /1993/	<p>9 дүгээр зүйл. Хот, тосгоны удирдлагын үндсэн зарчим</p> <p>Хот, тосгоны удирдлага нь үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, хууль дээдлэх болон оршин суугчдын ашиг сонирхлыг чөлөөлөх үндсэн зарчим баримтална.</p>
18.	ГААЛИЙН ТУХАЙ /2008/	<p>273 дугаар зүйл. Гаалийн улсын байцаагч</p> <p>273.4.Гаалийн улсын байцаагч нь “Гаалийн улсын байцаагч би, Монгол Улсын тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахын төлөө үнэнчээр зүтгэж, гаалийн хяналт, бүрдүүлэлт хийхдээ хууль, шударга ёсыг дээдлэн, гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, хэний ч нөлөөнд үл автахаа батлан тангараглая. Өргөсөн тангарагаас няцвал төрийн хуулийн хариуцлага хүлээнэ” гэсэн тангаргийг гаалийн улсын байцаагчийн эрх авахад өргөнө.</p>
19.	ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2010/	<p>41 дүгээр зүйл.Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, түүний бүрэн эрх, баталгаа</p> <p>41.4.Улсын байцаагч нь “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч би, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангахын төлөө үнэнчээр зүтгэж, гадаадын иргэн болон түүний баримт бичигт хяналт, шалгалт хийхдээ хүний эрх, хууль, шударга ёсыг дээдлэн, улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, хэний ч нөлөөнд үл автахаа батлан тангараглая. Өргөсөн тангаргаас няцвал төрийн хуулийн цээрлэл хүлээнэ” гэсэн тангараг өргөнө.</p>

20.	СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /2015/	5 дугаар зүйл.Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад баримтлах зарчим 5.1.3. шударга ёсыг сахих; 126 дугаар зүйл.Нам, эвслээс нэр дэвшүүлэх 126.5.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ нэр дэвшүүлэх нийтлэг журмаас гадна дор дурдсан журмыг баримтална: 126.5.1.нэр дэвшүүлэхдээ тухайн хүний Улсын Их Хурлын гишүүн байх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, эх орон, ард түмний тусын тулд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалан бэхжүүлэх төгс эрмэлзэл, шударга ёс , хууль дээдлэх ёс, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх чадварыг харгалзан үзэх; 140 дүгээр зүйл.Нам дангаар нэр дэвшүүлэх 140.2.1.тухайн хүний Ерөнхийлөгч байх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, эх орон, ард түмний тусын тулд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалан бэхжүүлэх төгс эрмэлзэл, шударга ёс , хууль дээдлэх ёс, Ерөнхийлөгчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх чадварыг харгалзан үзэх;
21.	УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ /2005/	5 дугаар зүйл.Намын үйл ажиллагааны зарчим 5.1.1.ардчилсан ёс, шударга ёс , эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх;
22.	ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ /2003/	3 дугаар зүйл.Төрийн аудитын үндсэн зарчим 3.1.Төрийн аудит нь хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх, төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартад нийцсэн байна. 7 дугаар зүйл.Үндэсний аудитын газар 7.5.Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд шударга ёсыг сахиулах үүднээс ёс зүйн дүрэм баталж мөрдүүлнэ.
23.	ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2012/	3 дугаар зүйл.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрх 3.4.Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанаас өмнө хүний эрх, эрх чөлөө, шударга ёс , хуулийг дээдлэн, хэрэг, маргааныг хэнээс ч хараат бусаар шийдвэрлэхээ батлан тангараглана.
24.	МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2016/	6 дугаар зүйл. Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго, чиг үүрэг 6.1.Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго нь зэвсэгт мөргөлдөөн ба нийтэд учирсан гамшигт байдлын үед хүн амд эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн тусламж үзүүлэхээс гадна хүнийг зовлон зүдгүүрт өртөхөөс сэргийлэх, учирсан зовлон зүдгүүрийг хөнгөвчлөх, шударга ёсны зарчимд үндэслэн хүнийг яс үндэс, иргэний харьяалал, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, бэлгийн чиг хандлага, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, боловсролоос үл хамааран хүний аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүмүүнлэг ёсыг хангахад дэмжлэг тусалцаа үзүүлэх, хүмүүс хоорондын ойлголцол, нөхөрлөл, хамтын ажиллагааг дэмжих, энх тайвныг бэхжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулахад оршино.
25.	ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ /2005/	8 дугаар зүйл.Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого 8.2.Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ дараахь бодлого баримтална: 8.2.1.ардчилал, шударга ёс , хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хүндэтгэх;
26.	ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ /1994/	2 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдэг

		2. Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс , цог хийморийг илэрхийлнэ.
--	--	--

ХАВСРАЛТ 3

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДВЭР

(Хүснэгт 8)

1.	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2007-6-13/ Дугаар 07	“Улсын Их Хурлаас 2001 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 43.1-д заасан хувиас илүү хэмжээгээр гадаадын иргэдийг авч ажиллуулсан тохиолдолд мөн хуулийн 43.2-т заасан хэмжээний төлбөрийг сар тутам төлнө”, мөн 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно”, 43.2 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...шударга ёс, ...тэгш байдал,...ийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийн “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, ...хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэж байна.
2.	Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт, Улсын Их Хурлын 1994 оны 60, 61 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 104, 105, 146 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай Маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /1996-5-29/ Дугаар 4	Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 104, 105 дугаар тогтоолууд гарч 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэхдээ 1997 онд хүрсэн байвал зохих хэмжээг тогтоов. Монгол Улсын Засгийн газрын 104 дүгээр тогтоолд зааснаар 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгогчид 1997 онд сард 7200-14400 төгрөгийн тэтгэвэртэй болох юм. Энэ нь 1995 оноос хойш тэтгэвэр тогтоолгогчдоос даруй 2-4 дахин бага байхаар тогтоогджээ. Энэхүү утгаар нь үзэхэд Улсын Их Хурлын 1994 оны 60, 61 дүгээр тогтоол, Засгийн газрын 1995 оны 104, 105 дугаар тогтоолууд нь тэтгэврийн насны иргэдийг 1995 оноос өмнөх ба хойшхи гэх мэт хугацаагаар ялгаварлан өөр өөр хэмжээтэй тэтгэвэр тогтоож, иргэд хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх тухай Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн байна.
3.	Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2015-6-10/ Дугаар 10	Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсгийн “Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ...-аар нь ялгаварлан

		гадуурхаж үл болно. ..." Арван зургадугаар зүйлийн 4/ дэх хэсгийн "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ...хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. ..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.
4.	Банкны тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2010-06-30/ Дугаар 03	Иргэн Д.Ламжав мэдээлэлдээ Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.4, 36.7, 36.11, 36.12 дахь хэсгүүд нь банкны хувьцаа эзэмшигчийн болон бусад этгээдийн өмчлөх эрхийг ноцтой хязгаарлаж, тэдгээрийг ялгаварлан гадуурхаж, эрх зүйн байдлыг үндэслэлгүйгээр дордуулан, улмаар тэгш эрхийн зарчмыг зөрчиж байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, ...Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалттай нийцэхгүй байна гэж үзжээ.
5.	Банкны тухай хуулийн зарим зүйл заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3, 14; 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай /Дүгнэлт/ /1998-1-28/ Дугаар 01	Банкны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 1, 2 дугаар заалт бүхэлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-ын "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.Хүн бүр хууль зүйн этгээд байна", 16 дугаар зүйлийн 14-т байгаа "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ... эрхтэй" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байх тул хянан үзэж, хэлэлцэж өгнө үү" гэжээ.
6.	Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг болон 40.1.1, 40.1.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2010-11-10/ Дугаар 06	Хүүхдэд олгох тэтгэлэгийг тогтоохдоо нас харгалзсан нь үндэслэл муутайн дээр уг заалт нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан хууль зүйн орчин болж чадсангүй. Хүүхдийн амьжиргааны зардлыг насаар нь ялгавартай тогтоосон нь бодит байдалд нийцэхгүйн зэрэгцээ насаар нь алагчилсан хууль зүйн орчныг бий болгосон байна. Үүнээс үзвэл хуулийн энэ заалт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т " Хүнийг ...нас...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна." гэж заасныг зөрчиж байна
7.	Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн заалт Үндсэн Хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2010-03-24/ Дугаар 01	"Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна" гэсэн заалтыг 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр батлагдаад одоо мөрдөж байгаа Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг зөрчсөн байна.
8.	Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын Хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай /Дүгнэлт/ /1996-03-27/ Дугаар 01	1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3-ын 5-д буй "Жагсаал, цуглааныг зохион байгуулагч нь сэтгэцийн өвчтэй хүмүүсийг жагсаал цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ" гэсэн заалт нь иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 26 дугаар зүйлийн "Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Энэ утгаар аливаа төрлийн ялгаварлан гадуурхлыг хуулиар хориглосон байх ёстой бөгөөд хуулиар бүх хүн ямар ч шинж тэмдгээр тухайлбал арьс-үндэс, арьс-өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал буюу бусад нөхцөл байдлаар ялгаварлахын эсрэг тэгш, үр нөлөөтэй хамгаалалтыг

		<p>баталгаатай болгоно" гэсэн заалтыг; мөн пактын 2 дугаар зүйлийн 1-ийн "Энэхүү пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон эрх мэдэлдээ байгаа бүх хүний энэхүү пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс-үндэс, арьс-өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн буюу бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй" гэсэн заалтыг тус тус зөрчиж тухайлбал бусад нөхцөл гэсэнд хамаарах эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхаж байгаа учраас Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2-ын "Монгол Улс, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" гэсэн заалтыг зөрчиж байна.</p>
9.	<p>Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2007-4-18/ Дугаар 04</p>	<p>Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсгийн "алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого" гэж дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хассаны дараа үлдсэн орлогыг, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн "Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлоходоо дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцно" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийн "шударга ёс, ..., тэгш байдал, ...-ийг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийн "шударга ёс, ..., тэгш байдал, ...-ийг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалт нь ижил бөгөөд харьцуулж болохуйц нөхцөлтэйгээр эрх зүйн харилцаанд оролцогчдод алагчлалгүй хандах, ялгаварлан гадуурхахгүй байх, адилхан эрх эдэлж, үүрэг хүлээх боломжийг төрийн зүгээс бүрдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулна гэсэн агуулгатай байдаг. Энэ ч үүднээс "Тэгш байдал нь төр харъяат субъектүүдээ хууль болон шүүхийн өмнө адилхан эрх эдэлж, үүрэг хүлээх боломжийг хангахад үйл ажиллагаагаа бүрэн чиглүүлснээр хэрэгжинэ"</p>
10.	<p>Засгийн газрын "журам батлах тухай" 2005 оны 208 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2006-12-20/ Дугаар 13</p>	<p>Уг тогтоол Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтуудыг засварлаж өөрчилсөн байдалтай гарсан нь "Хуульд өөрчлөлт оруулах тухай" Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг Засгийн газар зөрчсөн шинж чанартай байна.</p> <p>Мөн олимпийн наадамд ордог, ордоггүй гэдэг хандлага байдлаар спортын салбарынхныг эрхэлсэн ажил, сонгосон спортын төрлөөр нь ялгаварлан үзэх байдал бий болгосон нь олимпод ордоггүй спортын төрлийнхний хувьд сонирхлынхоо дагуу спортын төрлөө сонгон хөдөлмөрлөх, үр шимийг нь үзэх, хөдөлмөрөө үнэлүүлэх тэдний хууль ёсны эрхийг хязгаарлаж "эрхэлсэн ажил, мэргэжлээрээ ялгаварлагдан гадуурхагдахгүй байх" тухай Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2, "Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрлөх аятай нөхцлөөр хангагдах, хөдөлмөрөө үнэлүүлэх" тухай Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтуудыг тус тус зөрчиж байна</p>
11.	<p>Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар</p>	<p>"Монгол Улсын төр, засаг минь иргэн биднийгээ тэтгэвэрт гарсан он, нас, хүйсээр нь ялгаварлан гадуурхаж 1995 оноос</p>

	<p>тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /дүгнэлт/ /2005-6-17/ Дугаар 04</p>	<p>өмнө тэтгэврээ тогтоолгосон иргэдийн тэтгэврийн мөнгийг дутуу олгож 10 жилийн турш бие сэтгэлийн хүнд дарамт учруулж хохироож байна. 1995 оноос өмнө нийт 250 мянган иргэд тэтгэвэр тогтоолгож тэтгэврээ дутуу авч олон тэрбум төгрөгөөр хохирсон төдийгүй тэднээс энэ хугацаанд 170 мянга нь хорвоог орхин одсон бөгөөд одоо 80 хүрэхгүй мянга нь үлджээ. Өөрөөр хэлбэл жилд 17000, сард 1510, хоногт 47-48, цагт 2 тэтгэвэр авагч насан эцэслэж байна.</p> <p>Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь заалтыг зөрчиж байгааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээр хуулийн дагуу хэлэлцэж зохих дүгнэлт гарган шийдвэрлэж өгөхийг хүсч байна.” гэжээ.</p>
12.	<p>Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2011-12-27/ Дугаар 05</p>	<p>Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлээр нөхөх олговрын үнэлгээг тооцоолон тогтоож, тогтоосон хэмжээний нөхөх олговрыг олгохоос өмнө олборлох эрх бүхий этгээдийг “...уурхайн хаалт, нөхөн сэргээлт, байгаль орчны мониторингоос бусад үйл ажиллагааг...” тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд явуулахыг хориглосон нь бодит байдалд олборлох эрх бууу тусгай зөвшөөрлийг цуцалснаас өөрцгүй үр дагаврыг бий болгож байх бөгөөд ингэснээрээ Засгийн газар өөрт нь хуулиар ногдуулсан үүргийг “зөрчиж гүйцэтгэсэн”, Үндсэн хуулийн дээрх зүйл, заалтуудыг зөрчсөн үйл ажиллагаа болжээ.</p> <p>Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 болон 3, Арван зургадугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 болон 2, Нэгдүгээр зүйлийн 2, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгүүдийг тус тус зөрчсөн болохыг тогтоолгох шаардлагыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргаж байна” гэжээ</p>
13.	<p>Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн Хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2005-3-31/ Дугаар 02</p>	<p>1.Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Монгол Улсын Засгийн газраас гаргасан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянан үзэхээр зааж, уг хуулийн 8.1.2-т заасны дагуу хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заасан нь Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1, 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн.</p> <p>2. Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг захиргааны актад тооцож уг хуулийн 8.1.2-т заасны дагуу Захиргааны хэргийн шүүх хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заажээ. Энэ нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтыг зөрчсөн байна.</p>
14.	<p>Захиргааны Хэрэг Хянан Шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн Хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2006-1-25/ Дугаар 01</p>	<p>“Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2-ын “.../Ерөнхий сайд/... “ гэсэн хэсэгт Монгол Улсын Засгийн газраас гаргасан захиргааны актыг Захиргааны хэргийн шүүх магадлан хянаад, тус хуулийн 8.1.2-т заасны дагуу хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заажээ. Энэ заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” гэсэн 38 дугаар зүйлийн 1, “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар</p>

		өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчиж байна.
15.	Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2017-11-29/ Дугаар 07	Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “... хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, ... -ийн өмнө эрх тэгш байна...”, 2 дахь хэсгийн “Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын “... өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс ... сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ...”, 16 дахь заалтын “... тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ...” гэснийг тус тус зөрчсөн байх тул хянан хэлэлцэж дүгнэлт гаргаж өгнө үү.” гэжээ.
16.	Иргэн Г.Алтан, иргэн Ө.Мөнхтуяа, иргэн Д.Ламжав нараас компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 58 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 83 дугаар зүйл, 87 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /дүгнэлт/ /2002-06-26/ Дугаар 03	Компанийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”; Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно”; Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “... хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Монгол Улсын иргэн энэхүү үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”; Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”, 2 дахь хэсгийн “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно”, 3 дахь хэсгийн “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож болохгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн, “2002 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөлдөө Компанийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчиж байгаа тухай нэхэмжлэл гаргасан билээ. Энэхүү өргөдөлд дурдсан нэхэмжлэлтэй хамтатган “Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4, 67 дугаар зүйлийн 1 дэх заалт өргөдөлд иш татсан Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван есдүгээр 3 дахь хэсгийн заалтыг зөрчиж байна”, “Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 1, 2; 87 дугаар зүйлийн 2; 93 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”; Аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил

		<p>үйлчилнэ”; Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “...хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байна”, 2 дахь хэсгийн “Хүнийг хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно”; Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “... хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Монгол Улсын иргэн энэхүү үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”; Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудыг зөрчсөн байна гэжээ.</p>
17.	<p>Иргэний хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2006-4-12/ Дугаар 04</p>	<p>Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3-т “барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэж, Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.4-т “барьцааны зүйл нь ирээдүйд бий болох хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэж, .Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3-т “үүрэг гүйцэтгэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана” гэсэн нь нэгдүгээрт иргэний эрх зүйн талуудын тэгш эрхийн зарчим, хоёрдугаар, “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан зарчим, гуравдугаарт, Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан “шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”, дөрөвдүгээрт, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дүгээр хэсэг буюу “эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шудрага шүүхээр шүүлгэх... эрхтэй” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна</p>
18.	<p>Иргэний хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2006-6-15/ Дугаар 02</p>	<p>Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь заалтын “...Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө...өмчлөх...эрхтэй” гэснийг, Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2 дахь заалтын “...Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг, 174.3 дахь заалт “Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арванзургадугаар зүйлийн 14-д заасан “...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх...эрхтэй”, Арвандөрөвдүгээр зүйлийн 2-т заасан “...хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж</p>

		үл болно”, Дөчиндолдугаар зүйлийн 1-д заасан “...шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, Дөчиндолдугаар зүйлийн 2-т заасан “...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн байна гэжээ
19.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2004-04-21/ Дугаар 01	2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, үйлчилж эхэлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт: “Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байхад 3 шүүгч гурван өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай хоёр шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна, Мөн хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: “Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, 14 дэх хэсгүүдэд заасан заалтуудыг зөрчиж байна.333 Иймд, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд... төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж төрийн байгууллага, албан тушаалтанд өмгөөлөгч бус хүнээр /прокуророор/ эрх ашгаа хамгаалуулж болохоор заасан хэрнээ иргэн хүнд өмгөөлөгч бус хүнээр эрх ашгаа хамгаалуулах боломжийг олгоогүй байгаа нь бас л иргэний албан тушаалтнаас доогуур тавьж, хууль, шүүхийн өмнө ялгаварлан гадуурхаж байгаа хэрэг билээ гээд, иймд Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн заалтыг зөрчсөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болгож өгнө үү гэжээ.
20.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх /хойшид ИХШХШ гэх/ тухай хууль болон прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн заалт зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2003-04-30/ Дугаар 01	2002 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын хуулийн 31 дүгээр зүйл 31.1 заалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2; Дөчин есдүгээр зүйлийн 1,2; Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт мөн хуулийн 170 дугаар зүйл 170.3 заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, 14, Арван есдүгээр зүйл 1, 2 дахь хэсгийн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйл 1.2 “хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, хүнийг эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхахгүй байх”, Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 “төр, ...бусад байгууллагын албан тушаалтан иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
21.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	1/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлд “67.1.5. хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийн талаар холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа авах.” гэсэн заалт нэмэлтээр оруулж, уг ажиллагаа хийх үүргийг шүүгчид хүлээлгэсэн байна.. Нэхэмжлэгчийн нэхэмжлэлдээ дурдсан этгээдийг “хариуцагч” гэж үздэг бөгөөд хариуцагчаар оролцох иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн

	<p>/2018-02-02/ Дугаар 02</p>	<p>этгээдийн эрхгүй байгууллага, олон улсын байгууллага аль нь ч байсан “хэдий хэмжээний хөрөнгө, орлоготой, эсхүл хөрөнгө орлогогүй” байхаас үл хамааран шүүх иргэний хэргийг хянан шийдвэрлэх учиртай. Гэтэл “хариуцагч” гэж үзэж буй этгээдийнхээ хөрөнгө, орлогын мэдээллийг шүүхээр гаргуулах давуу байдлыг нэхэмжлэгчид хуулиар олгож байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөрөг үр дагавар үүсгэхийг үгүйсгэхгүй бөгөөд энэ нь Үндсэн хуулийн “... хөрөнгө чинээ, ... гээр нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж заасантай нийцэхээргүй байна.</p> <p>2/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт өөрчлөлт оруулжээ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлд шүүхээс гарах шийдвэрийн агуулгад тавигдах, нөхцөл шаардлагыг хуулиар тогтоож өгсөн байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар “Иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг баталгаажуулах арга хэмжээ”-нд 17 төрлийн ажиллагааг хамруулсан байх бөгөөд шийдвэр гүйцэтгэлийн байгууллага нь дээрх ажиллагааг хуулиар тогтоосон арга, журмын дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 20.5 дахь хэсэг нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт орсон өөрчлөлттэй шууд холбоотой бөгөөд энэ нь Үндсэн хуулийн “Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн гэж үзэхээр байгааг дурдах нь зүйтэй гэжээ.</p>
22.	<p>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай /2002-6-05/ Дугаар 01/</p>	<p>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй “Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй гэсэн заалтын дараа “Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “...шударга шүүхээр шүүлгэх”, Дөчин есдүгээр зүйлийн 1-ийн “шүүгч хараат бус байх” заалтыг тус тус зөрчсөн байна” гэжээ</p>
23.	<p>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2; 184 дүгээр зүйлийн 5; 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /дүгнэлт/ /2002-04-03/ Дугаар 01</p>	<p>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт, 184 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөнийг хянан үзээд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй “Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй гэсэн заалтын дараа “Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “...шударга шүүхээр шүүлгэх”, Дөчин есдүгээр зүйлийн 1-д заасан “шүүгч хараат бус байх” заалтыг тус тус зөрчсөн байна, харин хуулийн 177 дугаар зүйлийн 2, 184 дүгээр зүйлийн 5 дахь заалтууд, Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1, 2; Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгүүдийг зөрчөөгүй байна гэжээ.</p>

24.	Компанийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2012-10-10/ Дугаар 04	Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.11, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 30 дугаар зүйлийн 30.1, 33 дугаар зүйлийн 33.7, 84 дүгээр зүйлийн 84.1, 84.10 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 2, 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 4, 17 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай
25.	Компанийн тухай хуулийн зарим заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2002-11-13/ Дугаар 03	Компанийн тухай хуулийн 58 дугаар зүйл нь миний үзэж байгаагаар Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2; Арван дөрөвдүгээр зүйлийн 2; Арван зургадугаар зүйлийн 3; Арван есдүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтуудыг зөрчиж байна. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Компанийн энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй"; 87 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувь эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 87 дугаар зүйлийн 1-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй, Хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, хуулийн 83 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсэг нь "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байна"; "Хүнийг ... хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэжээ.
26.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаархи маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /1996-12-02/ Дугаар 09	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн дөрөв дэх хэсэгт заасан "дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт буй "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна" гэснийг, хуулийн 16 дугаар зүйлийн 9-т "хүн бүр шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй" гэж тогтоосныг, хуулийн 1 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт "Ардчилсан ёс ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэснийг, хуулийн 60 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт "Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд ... томилно" гэж заасныг, хуулийн 16 дугаар зүйлийн 10-т "Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэжээ.
27.	Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 92 дугаар тогтоол, 2012 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 153 дугаар тогтоолын холбогдох заалт Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 92 дугаар тогтоол, 2012 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 153 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн в/ заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал,

	/2014-1-22/ Дугаар 02	байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 5/ дахь заалтад “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” гэснийг зөрчсөн тухай.
28.	Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2005-12-14/ Дугаар 02	“Засгийн газраас 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдөр баталсан “Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 22 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт “1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнөх хугацааны тэтгэвэр тогтоолгох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 120000 төгрөгөөр тогтоосугай” гэж заасан нь тэтгэврийн насны иргэдийг 1998 оноос өмнө, хойно гэж хоёр хувааж ялгавартай хандсан, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна” гэжээ.
29.	Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2006-2-22/ Дугаар 02	Засгийн газар нь 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг хэрэгжүүлснээс гарах үр дагаврыг шийдвэрлээгүй юм. Энэ нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь заалт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтыг зөрчлөө. Иймд Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт, түүнийг гаргахтай холбоотой үйл ажиллагаа Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурсан заалтуудыг зөрчсөн эсэхийг тогтоож өгнө үү” гэжээ.
30.	Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх /хойшид ИХШХШ гэх/ тухай хууль болон прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2003-06-20/ Дугаар 02	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "...энэ хуулийн 20.2; 38.9; 65.1.3; 65.1.6; 65.1.10 дахь ...зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй" гэсэн заалт, мөн Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцож, өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ" гэсэн заалтын "...өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ" гэсэн хэсэг, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Прокурор энэ хуулийн 16.1-д заасан ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 34 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ" гэсэн заалтын "...34 дүгээр" гэсэн хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "Монгол Улсын иргэн ...шударга шүүхээр шүүлгэх ...шүүхийн шийдвэрийг давж заалдах ...эрхтэй", Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.
31.	Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай / 2018-8-22/ Дугаар 10	Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний

		эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж тус тус заасныг зөрчсөн байна гэжээ.
32.	Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэсэн тухай /2018-11-30/ Дугаар 03	Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлан гаргасан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчсөн байна
33.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2015-9-30/ Дугаар 12	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна.” гэж заасны “...бусад төрийн албан хаагч...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг зөрчсөн байна гэжээ.
34.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нам, эвслийг бүртгэхээс татгалзах үндэслэлийг заасан 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9/ дэх заалтын “...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”, мөн зүйлийн 10/ дахь заалтын “...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно...” гэснийг тус тус зөрчсөн байна гэжээ.
35.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2010-1-22/ Дугаар 01	2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9/ дэх заалтын “...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”, мөн зүйлийн 10/ дахь заалтын “...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно...” гэснийг тус тус зөрчсөн байна гэжээ.
36.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг	Монгол Улсын Их Хурал 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч,” гэснийг “Төрийн жинхэнэ албан

	<p>зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэсэн тухай /2015-11-27/ Дугаар 10</p>	<p>хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан,” гэж өөрчилж Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийн үндэслэлийн агуулгад нийцүүлсэн</p>
<p>37.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2012-05-02/ Дугаар 03</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9-д “Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно.” гэсэн заалт оруулснаас үүдэн уг хуульд 6.7.2, 27.5.4, 48.2, 48.7, 49.1.1, 49.1.2, 49.1.3, 49.1.7, 49.2 гэсэн зохицуулалтуудыг хийжээ. Эдгээр нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т “Хүнийг...эрхэлсэн ажил, ... үзэл бодол, -оор нь ялгаварлан гадуурхаж үл болно...”, Арван зургадугаар зүйлийн 9-д “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...”, Арван зургадугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, ... эрх чөлөөтэй...”, Хорин нэгдүгээр зүйлийн 2-т “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.”, Хорин гуравдугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэсэн заалттай тус тус зөрчилдсөн байна гэжээ.</p>
<p>38.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2012-03-28/ Дугаар 02</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9-д “Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно.” гэсэн заалт оруулснаас үүдэн уг хуульд 6.7.2, 27.5.4, 48.2, 48.7, 49.1.1, 49.1.2, 49.1.3, 49.1.7, 49.2 гэсэн зохицуулалтуудыг хийжээ. Эдгээр нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т “Хүнийг...эрхэлсэн ажил, ...үзэл бодол, -оор нь ялгаварлан гадуурхаж үл болно...”, Арван зургадугаар зүйлийн 9-д “...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...”, Арван зургадугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, ...эрх чөлөөтэй...”, Хорин нэгдүгээр зүйлийн 2-т “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.”, Хорин гуравдугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг</p>

		сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэсэн заалттай тус тус зөрчилдсөн байна гэжээ.
39.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн холбогдох заалтууд Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан хэлэлцсэн тухай /1993-12-22/ Дугаар 04	Улсын Бага Хурлаас 1992 оны 4 дүгээр сарын 4-нд баталсан Монгол Улсын Их хурлын сонгуулийн хуульд сонгогчдын эрх тэгш байх, чөлөөтэйгөөр сонгох эрхийг алдагдуулан Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчив, 1994 онд сонгуулийн хууль Үндсэн хуультай харшилж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрх хууль ёсны эсэх талаар ард нийтийн санал асуулга явуулж өгөхийг хүссэн нь Үндсэн хуулийн Цэцийн шийдэх эрх хэмжээний асуудал биш, Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн зарим заалт, 33, 35, 36, 38 дугаар зүйлийн зарим заалтууд боловсронгуй бус байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4-т буй Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно гэсэн заалтын хүрээнд хуульчлагдсан тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралтын хуулийн нэгдүгээр зүйлийн 2-ын 2 дахь заалтаар Улсын Бага Хуралд олгогдсон хууль тогтоох эрх хэмжээнд шийдвэрлэгдсэн байна гэжээ.
40.	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2011-10-21/ Дугаар 03	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг тус тус зөрчсөн гэжээ.
41.	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2012-02-15/ Дугаар 02	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ...”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэснийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэж, хянан хэлэлцсэн байна.
42.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/03 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн эсэх тухай маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2009-5-27/	2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн ... 5 дахь заалтын “Импортоор авсан бараа”-нд хамаарах “0.20” гэснийг “0.35” гэж ...өөрчилсүгэй” гэж эх орны үйлдвэрийн болон импортын литр пиво тутамд онцгой албан татварыг ялгавартайгаар ногдуулахаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 4 дүгээр сарын 13-ны

	Дугаар 02	өдрийн 2/03 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон Онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн байх тул 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "...5 дахь заалтын "Импортоор авсан бараа"-нд хамаарах "0.20" гэснийг "0.35" гэж" өөрчилсөн хэсгийг хүчингүй болгох тухай.
43.	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж эцэслэн шийдвэрлэсэн тухай /2016-11-16/ Дугаар 05	Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт "... энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.", Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ." гэснийг зөрчсөн байна гэжээ.
44.	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2016-09-28/ Дугаар 10	Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт "... энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.", Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэжээ.
45.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл, түүний тайлбар нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2008-4-16/ Дугаар 05	Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйл, түүний тайлбар нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д "...Хүнийг ...үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж үл болно...", Арван зургадугаар зүйлийн 9-д "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй", Арван зургадугаар зүйлийн 10-т "...аль нэг нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно", Арван зургадугаар зүйлийн 13-т "халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ...Мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно", Арван зургадугаар зүйлийн 14-д "Монгол Улсын олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно.", Арван зургадугаар зүйлийн 18-д "Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй" Хорин есдүгээр зүйлийн 2-т "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална" гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэжээ.

46.	<p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулийн зарим заалт Монгол Улсын хууль зөрчсөн эсэх тухай /Дүгнэлт/ /1998-2-24/ Дугаар 02</p>	<p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд буй заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалтыг; мөн хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "Иргэд ... өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй" гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэжээ.</p>
47.	<p>Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2007-01-10/ Дугаар 01</p>	<p>Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн /цаашид НӨАТ гэх/ 9 дүгээр зүйлийн 9.3-д "Жилийн 10.0 сая ба түүнээс доош төгрөгийн татвар ноогдох борлуулалтын орлоготой үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө. Энэ заалт импортлогчдод хамаарахгүй" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна гэжээ.</p>
48.	<p>Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль, Үндсэн хуулийн хавсралт хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2005-04-13/ Дугаар 03</p>	<p>Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн удиртгал хэсгийн "Тариф болон худалдааны бусад саад тотгорыг багасгах, түүнчилэн олон улсын худалдаан дахь ялгаварлан гадуурхах явдлыг арилгахад чиглэсэн адил тэгш нөхцөл бүхий харилцан ашигтай тохиролцоонд хүрэх" гэсэн заалт болон 1 дүгээр зүйлийн "Үндэсний нэн тааламжтай нөхцөл", 3 дугаар зүйлийн "Дотоодын татвар ногдуулалт болон зохицуулалтын үндэсний нөхцөл"-ийг зөрчсөн байна</p>
49.	<p>Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай /Дүгнэлт / /1996-10-30/ Дугаар 08</p>	<p>Өршөөл үзүүлэхдээ ингэж "60-аас дээш насны эрэгтэйчүүд" гэсэн хязгаар тогтоож байгаа явдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заагдсан "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна", мөн "хүнийг ... нас хүйсээр нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалт, 16 дугаар зүйлийн 11-д заагдсан "Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй", "гэр бүл, эх нялхас хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэсэн заалтуудыг Монгол Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн тогтоол зөрчиж байна гэжээ.</p>
50.	<p>Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2018 оны 49 дүгээр тогтоол, 2019 оны 22, 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн маргааныг хянан шийдвэрлэсэн тухай</p>	<p>Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3 дахь заалт нь "өөр ажилд шилжих", "хүндэтгэн үзэх бусад шалтгаан" гэсэн хоёр нөхцөлийг шаардаж байна. Гэтэл Д.Гантулга гишүүн нь өөр ажилд шилжих болсон талаар хүсэлтдээ дурдаагүй, дараа нь томилогдоогүй. Мөн түүний чөлөөлөгдөхийг хүссэн өргөдөлд "хүндэтгэн үзэх шалтгаан"-ы талаар огт дурдаагүйгээс гадна нотлох баримт хавсаргаагүй тул хүндэтгэн үзэх ямар нэг шалтгаан бүрдээгүй байна. ...</p>

	/2019-5-27/ Дугаар 02	Тэгэхээр хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй байхад түүнийг чөлөөлсөн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэснийг зөрчсөн гэжээ.
51.	Сонгуулийн тухай хуулийн 160 дугаар зүйлийн 160.5 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2016-09-21/ Дугаар 09	Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Сонгуулийн тухай хуулийн 160 дугаар зүйлийн 160.5 дахь хэсэгт "Нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасагдсаны улмаас дахин сонгууль явагдсан бол хасагдсан нэр дэвшигч хүн зургаан жилийн хугацаанд сонгуульд нэр дэвших болон төрийн албанд томилогдох, сонгогдох эрхээ алдах ба урьд явагдсан сонгуулийн сурталчилгааны болон зохион байгуулалтын бүх зардлыг нөхөн төлөх үүрэгтэй" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно ..." гэснийг тус тус зөрчсөн.
52.	Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийн зохицуулалтаар Цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон холбогдох хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай / 2019-1-16/ Дугаар 01	Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт "Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...", мөн зүйлийн 10 дахь заалтад "... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. ...", мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэсэн хэм хэмжээг тус тус зөрчсөн гэж үзсэн байна.
53.	Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай /1994-01-12/ Дугаар 02	"Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ" гэсэн нь Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 2 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг тус тус зөрчиж байна гэжээ.
54.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь заалт үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2006-9-20/ Дугаар 09	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад тусгасан хязгаарлалт нь хуулийн этгээд болох аж ахуйн нэгж болон аж ахуйн нэгж байгуулан үйл ажиллагаа явуулах Монгол Улсын иргэн хуулийн хүрээнд, хуулиар хориглоогүй үйл ажиллагаа эрхлэн шударгаар чөлөөтэй өрсөлдөн, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхийг хязгаарлан хориглож буйгаараа Үндсэн хуулийн заалтуудыг зөрчиж байна
55.	Улсын Их Хурлын дэргэдэх сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 9 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаархи маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 09 тоот тогтоолоор Д.Нармандах, Х.Баянмөнх нарыг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтаас хасах шийдвэр гаргасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 болон 10-т байгаа Монгол Улсын иргэн ... сонгогдох эрхтэй ...

	/Дүгнэлт/ /1996-06-20/ Дугаар 05	нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй. Аль нэгэн намд эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд нь хувь хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглоно ... гэсэн заалтуудыг зөрчсөн гэж үзэж байна
56.	Улсын Их Хурлын дэргэдэх сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 9 дүгээр тогтоол үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол / /1996-09-11/ Дугаар 04	Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 6 дугаар сарын 6-ны 09 тоот тогтоолоор Д.Нармандах, Х.Баянмөнх нарыг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаас хасах шийдвэр гаргасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9, 10-т байгаа "Монгол Улсын иргэн сонгогдох эрхтэй. ... нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй. Аль нэгэн намд эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд нь хувь хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн гэж үзэж байна
57.	Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай /Дүгнэлт/ /2007-11-16/ Дугаар 11	Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтууд нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2; 3 дугаар зүйлийн 1; 14 дүгээр зүйлийн 1; 16 дугаар зүйлийн 10; 19 дүгээр зүйлийн 1, 2, 3; 21 дүгээр зүйлийн 2; 23 дугаар зүйлийн 1; 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна" гэжээ
58.	Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /дүгнэлт/ /2005-9-30/ Дугаар 07	Улсын Их Хурлын гишүүдийн дунд эрх зүйн ялгаварлал бий болгож тодорхой зарим гишүүд, тухайлбал 8-аас дээш суудал бүхий намын Улсын Их Хуралд сонгогдсон гишүүний "бүлгийн харъяаллаас татгалзан гарч өөр бүлэгт нэгдэн орж болох", бие даан нэр дэвшиж сонгогдсон гишүүний "аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох" зэрэг эрхээ эдлэх боломжгүйд хүрч Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...тэгш байдал .. нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын "Аль нэг нам ...-ын гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно" гэснийг зөрчиж байна
59.	Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай /2017-12-20/ Дугаар 02	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад "гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан бол гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ." гэж заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна гэжээ.
60.	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай /дүгнэлт/ /2000-3-15/ Дугаар 03	Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт" нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т заасан "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", жаран наймдугаар зүйлийн 1-д заасан "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно", далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

61.	<p>Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /тогтоол / /2000-11-29/ Дугаар 02</p>	<p>Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт” нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т заасан “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, жаран наймдугаар зүйлийн 1-д заасан “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно”, далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.</p>
62.	<p>Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг Зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /2014-12-12/ Дугаар 02</p>	<p>Улсын Их Хурлаас 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчин” гэдэгт хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчин хамаарахгүй” гэсэн хэсэг нэмсэн. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууц гэдгийг энэ хуульд дараахь утгаар ойлгоно” гээд 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад “эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг” гэж заасан. Хуулийн дурдсан хэсэг, заалтаас харахад хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчнөөр өвчилсөн хүний мэдээллийг хувь хүний нууцын төрлөөс хассан байна. Ингэснээр Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно”, Арван зургадугаар зүйлийн 13/ дахь заалтын “...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, ... -ыг хуулиар хамгаална”, мөн зүйлийн 17/ дахь заалтын “... Хүний эрх, нэр төр, алдар хүнд, ...-г хангах зорилгоор задруулж үл болох ... хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэснийг тус тус зөрчсөн байна</p>
63.	<p>Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2014-9-10/ Дугаар 05</p>	<p>Улсын Их Хурлаас 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчин” гэдэгт хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчин хамаарахгүй” /цаашид “ХДХВ/ДОХ” гэх/ гэсэн хэсэг нэмсэн. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууц гэдгийг энэ хуульд дараахь утгаар ойлгоно.” гээд 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад “эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг;” гэж заасан. Хуулийн дурдсан хэсэг, заалтаас харахад хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол</p>

		<p>хомсдол өвчнөөр өвчилсөн хүний мэдээллийг хувь хүний нууцын төрлөөс хассан байна. Ингэснээр Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно.", Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын "... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, ... -ыг хуулиар хамгаална;", мөн зүйлийн 17 дахь заалтын "... Хүний эрх, нэр төр, алдар хүнд, ...-г хангах зорилгоор задруулж үл болох ... хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэснийг тус тус зөрчсөн байна.</p>
64.	<p>Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, 17.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /дүгнэлт/ /2010-11-24/ Дугаар 08</p>	<p>Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн "Хуульч нь хууль зүйн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, 3 жил тутам сургалтын тодорхой багц цаг хангаж байх үүрэг хүлээнэ." гэсэн нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг, 17.3 дахь хэсгийн "Шүүх, прокурорын байгууллагад ажиллагсдын сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ." гэсэн нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг, 17.4 дэх хэсгийн "Хуульчийн сургалтад хамрагдах журмыг Зөвлөл тогтооно." гэсэн нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг, 18 дугаар зүйлийн 18.1.2-т "хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, авбал зохих багц цагийг хангаагүй;" гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 4, 7 дахь заалт болон Тавин нэгдүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна гэжээ.</p>
65.	<p>Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.7, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2014-3-12/ Дугаар 03</p>	<p>Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.7 дахь хэсэгт "... Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна." гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.", мөн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гээд мөн зүйлийн 2 дахь заалтад "давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх", Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ." гэсэн заалтуудтай зөрчилдөж байна. Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.7 дахь заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэжээ.</p>
66.	<p>Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /2015-2-11/ Дугаар 02</p>	<p>Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэргэжлээрээ ажиллах гэсэн ойлголтыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэх ойлголтоор явцууруулан хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан зарим иргэний шүүгчээр томилогдон ажиллах эрхийг хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтын "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... эрхтэй. ..." гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэл болж байна. Ингэснээрээ Үндсэн хуулийн</p>

		Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “... шударга ёс, ... тэгш байдал ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн гэжээ.
67.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2013-12-11/ Дугаар 05	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “Өмгөөлөгч багшлах, эрдэм шинжилгээний болон өмгөөллийн хуулийн этгээд, Хуульчдын холбоонд хамаарахаас бусад ажил, албан тушаалыг хавсран эрхлэхийг хориглоно.” гэсэн заалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... эрхэлсэн ажил...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно”, Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй ...” гэснийг зөрчсөн гэжээ.
68.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зарим зүйл заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2014-10-22/ Дугаар 06	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 4/, Арван есдүгээр зүйлийн 1, Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох зүйл заалтыг тус тус зөрчсөн гэж үзжээ.
69.	Цөмийн энергийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /дүгнэлт/ /2009-11-13/ Дугаар 05	Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 1, 2, 3, Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалт, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн тухай.
70.	Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2017-10-4/ Дугаар 05	Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалт, Дөчин есдүгээр зүйлийн 3, 4, Тавин нэгдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай
71.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2, 111.5 заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2006-12-14/ Дугаар 12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2-ын “Жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна”; 111.5-ын “Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “...гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэснийг зөрчсөн эсэх тухай.
72.	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2014-01-15/ Дугаар 01	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсгийн “Давж заалдах шатны шүүх ял оногдуулсан, эсхүл цагаатгагдсан этгээдийн гэм буруутай эсэх асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл энэ хуулийн 304 дүгээр зүйлд заасан журмын дагуу шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогчийн өмгөөлөгч гомдол гаргах, улсын яллагч, эсхүл дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.” гэж заасны “... шүүгдэгч, цагаатгагдсан этгээд,

		хоширогчийн өмгөөлөгч гомдол гаргах ... эрхтэй." гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй." гэснийг зөрчсөн тухай.
73.	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2017-4-12/ Дугаар 03	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсэгт "Хяналтын шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй ба уг этгээд энэ тухай хүсэлтээ бичгээр гаргасан бол заавал оролцоно." гэж заасны "... шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй ..." гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "... өөрийгөө өмгөөлөх, ... шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, ... эрхтэй. ..." гэснийг тус тус зөрчсөн эсэх тухай
74.	Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /тогтоол/ /2006-07-05/ Дугаар 03	.Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн заалтыг зөрчсөн гэжээ.
75.	Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйлийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2012-5-09/ Дугаар 03	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйлийн 294.1-д "Захирагч эрх мэдэл албан тушаалынхаа байдлыг урвуулсан, хэтрүүлсэн, албаны бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс үлэмж хэмжээний хохирол учирсан бол ... ял шийтгэнэ.", мөн 294.2-т "Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол, хүнд хор уршиг учирсан бол ... ял шийтгэнэ." гэж заасан байдаг. Эрүүгийн хуулийн уг 294.1, 294.2 дахь заалтад захирагч албаны бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс хохирол, хүнд хор уршиг учирсан бол гэмт хэрэгт тооцохоор заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Хүнийг ...нийгмийн байдал ... эрхэлсэн ажил, албан тушаал ...боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэж заасныг зөрчсөн гэжээ.
76.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2019-03-13/ Дугаар 01	Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтын холбогдох хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх тухай
77.	Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт, мөн зүйлийн 17.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт "Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг анагаах ухааны боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгссөн дараахь эмнэлгийн мэргэжилтэнд олгоно" хэмээгээд тус хуулийн 17.3.1-д "эрх, сум, тосгон, сум дундын эмнэлэгт эхний жилд, аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нүүр

<p>/2009-4-15/ Дугаар 03</p>	<p>ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх хувийн хэвшлийн эмнэлэгт хоёр дахь жилдээ тус тус дадлагажигчаар ажилласан, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн их эмч” гэсэн заалт болон мөн зүйлийн 17.6 дахь хэсэгт “Дадлагжигчаар ажиллуулахад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардлагагүй” гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн;” Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ...эрхэлсэн ажил, албан тушаал, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”; Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийн “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ...хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;” 6 дахь хэсгийн “...эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй;” 18 дахь хэсгийн “...оршин суух газраа сонгох, гадаадад явах...” гэсэн баталгаатай эдлэх эрх, эрх чөлөөг зөрчсөн гэжээ.</p>
----------------------------------	---

1/ Австрали улс

2004 оны Насаар ялгаварлахын эсрэг хууль
 1991 оны Ялгаварлангийн эсрэг хууль
 1977 оны Ялгаварлангийн эсрэг хууль
 1986 оны Австралийн Хүний эрхийн комиссын хууль
 1992 оны Хөгжлийн бэрхшээлтэйгээр ялгаварлахын эсрэг хууль
 2001 оны Арьсны өнгө шашин шүтлэгийг хүлцэх тухай хууль
 1975 оны Арьс өнгөөр ялгаварлахын эсрэг хууль

2/ Болива улс

2010 оны Арьсны өнгөөр болон бүх төрлийн ялгаварлангийн эсрэг хууль

3/ Канад улс

1982 оны Канадын хүний эрх, эрх чөлөөний дүрэм
 1986 оны Канадын Хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлын тухай хууль
 1977 оны Канадын Хүний эрхйн хууль
 2002 оны Онтарчууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай хууль
 1976 оны Хүний эрх, эрх чөлөөний дүрэм
 1971 оны Канадын олон төрлийн соёлын хэв маягийн тухай хууль

4/ Колумба улс

2011 оны Колумбын ялгаварлангийн эсрэг хууль

5/ Европын холбоо

Европын Хамтын Нийгэмлэгийн Зөвлөлийн 1976 оны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны сургалт, тушаал дэвших болон ажиллах нөхцлийг хангахад эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш хандах тухай олон улсын зарчмыг хэрэгжүүлэх Зааварчилгаа /Directive 76/207/EEC/

Европын Холбооны 2000 оны Ялгаварлахын эсрэг Зааварчилгаа /Directive 2000/43/EC on Anti-discrimination/

Европын Холбооны 2004 оны Ажил үйлчилгээ авахад эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш хандах тухай зарчмыг хэрэгжүүлэх тухай Зааварчилгаа / Directive 2004/113/EC/

Европын Холбооны зөвлөлийн 2006 оны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байранд эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш хандах болон тэгш боломж олгох тухай зарчмыг хэрэгжүүлэх Зааварчилгаа /Equal Treatment Directive 2006/54/EC/

Европын Холбооны Хүний үндсэн эрхийн тухай конвенцийн 21 дүгээр зүйл /хүнийг хөгжлийн бэрхшээл, нас, бэлгийн чиг хандлагаар зэрэг бүх төрлөөр ялгаварлахыг хориглосон/

6/ France

1598 оны Нантесын хууль/Edict of Nantes/

7/ ХБНГУ

2006 оны Тэгш хандах тухай хууль

8/ Хонг-Конг

Хөгжлийн бэрхшээлийн тухай Тогтоол -1995

Гэр бүлийн байдлаар ялгаварлахын эсрэг Тогтоол - 1997

Хүний эрхийн Хонг-Конгийн хууль - 1991

Арьс өнгөөр ялгаварлахын эсрэг Тогтоол - 2008

Хүйсээр ялгаварлахын эсрэг хууль - 1996

9/ Энэтхэг улс

1949 оны Энэтхэгийн Үндсэн хуулийн 14, 15, 16, 17 дугаар зүйл

1850 оны Ангит нийгэм дэх хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай заалтыг халах тухай хууль

1956 оны эмэгтэй хүний “хязгаарлагдмал өмчлөгч” гэсэн байдлыг халах тухай хууль

1989 оны Ангит нийгэм болон овог тогтоох /харгис явдлаас сэргийлэх тухай/ хууль

10/ Олон улсад

1925 оны Тэгш хандах / гэмтлийн нөхөн төлбөр/ тухай конвенц

1960 оны Боловсрол дахь ялгаварлахын эсрэг конвенц

1962 оны Тэгш байдал Нийгмийн халамжийн тухай конвенц

1975 оны Гадаад ажиллагсдын ажлын дарамттай нөхцлийн тухай болон тэдэнд тэгш хандах, тэгш боломж олгох тухай конвенц

1979 оны Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг устгах тухай конвенц

1965 оны Бүх төрлийн арьсны өнгөөр ялгаварлахыг устгах тухай конвенц

2006 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай конвенц
хууль
1958 оны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байран дахь ялгаварлахын эсрэг конвенц
1951 оны Ижил цалин хөлс олгох тухай конвенц
2000 оны Хүний эрхийн тухай Европын конвенцийн 12 дугаар нэмэлт протокол
2013 оны Бүр төрлийн арьс, арьсны өнгөөр ялгаварлахын эсрэг хүлцэхүйн тухай Америк улсуудын
конвенц
2013 оны Бүр төрлөөр ялгаварлахын эсрэг хүлцэхүйн тухай Америк улсуудын конвенц

11/ Израйл улс
1988 оны Хөдөлмөр эрхлэлт / тэгш боломжийн/ тухай хууль
2000 оны Бараа, үйлчилгээ авах, олон нийтийн үзвэрийн газарт ялгаварлахын эсрэг хууль

12/ Нидерланд улс
1881 оны Дани улсын Эрүүгийн хуулийн 137 /в-ж/зүйлийн 1/4/ дэх зүйл

13/ Шинэ Зеланд улс
1990 оны Хүний эрхийн хууль 19 дүгээр зүйл
1993 оны Хүний эрхийн хууль

14/ Польш улс
1264 оны Калисзийн хууль
1573 оны Варшавын хууль

15/ ОХУ
1917 оны Оросын ард түмний эрхийн тунхаг

16/ Өмнөд Африк
1996 оны Өмнөд Африкийн Үндсэн хуулийн 9 дүгээр зүйл
1998 оны Хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлын тухай хууль
2000 оны тэгш байдлыг дэлгэрүүлэх, Шударга бус ялгаварлалтаас сэргийлэх тухай хууль

17/ИБУИНВУ
1995 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хууль
2005 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хууль
1970 оны Тэгш цалин хөлс авах тухай хууль
2006 Тэгш байдлын тухай хууль
2010 оны Тэгш байдлын тухай хууль
1965 оны Арьсны хамаарлын тухай хууль
1968 оны Арьсны хамраарлын тухай хууль
1976 оны Арьсны хамаарлын тухай хуульд 2000 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан
1918 оны Хүмүүсийн төлөөлөгчийн /бизнес тэгш зөвшөөрөл олгох/ хууль
1975 оны Хүйсээр ялгаварлах хуульд 2002 оны Хүйсээр /сонгуульд нэр дэвшигчийг/ ялгаварлах
тухай хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан
2003 оны Ажилтны тэгш байдлын хангах (бэлгийн чиг хандлага) журам
2003 оны Ажилд ороход тэгш хандах (шашин, итгэл үнэмшил) журам
2006 оны Ажилд ороход тэгш хандах (нас) журам

18/ АНУ
1975 оны Насаар ялгаварлахын эсрэг хууль
1967 оны Хөдөлмөр эрхлэлтэд насаар ялгаварлахын эсрэг хууль
1945 оны Ялгаварлахын эсрэг Аласкагийн хууль
1990 оны Хөгжлийн бэрхшээлтэй Америк иргэдийн хууль
1959 оны Калифорни мужийн Шударга хөдөлмөр эрхлэлт, орон байрны шударга байдлын тухай
хууль
1866 оны Иргэний эрхийн хууль
1871 оны Иргэний эрхийн хууль
1957 оны Иргэний эрхийн хууль
1964 оны Иргэний эрхийн хууль
1968 оны Иргэний эрхийн хууль
1991 оны Иргэний эрхийн хууль
1974 оны Ажилд авахад үл алагчилах тухай хууль
1963 оны Тэгш цалин хөлс олгох тухай хууль
1969 оны Ерөнхийлөгчийн 11478 дугаар зарлиг

2000 оны Ерөнхийлөгчийн 13166 дугаар зарлиг “Англи хэлээр үл яригч этгээдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах хууль”
1941 оны Шударга Хөдөлмөр эрхлэлтийн хууль
1993 оны Гэр бүл, эрүүл мэндийн шалтгаанаар амралт авах хууль
1868 оны Үндсэн хуулийн 14 дүгээр нэмэлт, өөрчлөлт
2008 оны Генийн мэдээллийн ялгаварлалын эсрэг хууль
2012 оны Орон гэргүйчүүдийн хүний эрхийн хууль
1912 оны Lloyd–La Follette хууль
2009 оны Lilly Ledbetter шударга цалин хөлс олгох хууль
2018 оны Масачутессийн Жендэрт суурилсан ялгаварлалын эсрэг санаачлага
2010 оны Нью Жерси Үг хэлээр доромжлохын эсрэг хүний эрхийн хууль
2002 оны Мэдэгдэл болон Холбооны ажилтныг алагчилахын эсрэг болон Хариу хууль
1965 оны Санал өгөх эрхийн хууль
1978 оны Жирэмсэн байдлаар нь алагчилахын эсрэг хууль
1973 оны Сэргээн засах үйлчилгээний тухай хууль